



ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ, ХҮҮХЭД ХАМГААМЫН САЙН ТУРШЛАГА

Улаанбаатар хот
2020 он

УИХ.МАН
СУДАЛГААНЫ САН



ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ, ХҮҮХЭД ХАМГААЛМЫН САЙН ТУРШЛАГА

(Монголын болон бусад улсын жишээ)

Улаанбаатар хот
2020 он

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Төслийн нэр: Хүүхдэд ээлтэй аюулгүй, эрх тэгш, тэгш хамруулсан боловсролын сайн туршлага
Агуулга: Боловсролын үйл ажиллагаанаас маргиналчлагдан тусгаарлагдах эрсдэлтэй бүлгийн хүүхдүүдийг эрх тэгш, тэгш хамруулан, хүүхдэд ээлтэй, аюулгүй сургуулийн орчныг бүрдүүлсэн Монголын болон бусад орны туршлагыг түгээх
Зөвлөх: Социологийн ухааны доктор Н.Болдмаа
Эмхэтгэсэн: Я.Мөнхчимэг
Хянасан: Д.Тунгалаг
Редактор: Ч.Бат-Уянга
Орчуулагч: Т.Бэхцэцэг, О.Одончимэг
Зураач: Б.Билгүүн

“Боловсролын төлөө чанга дуугарцгаая!” төслийн санхүүгийн дэмжлэгтэй хэвлэв.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ 4

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСАД БИЙ БОЛЖ БУЙ САЙН ТУРШЛАГААС

Тэгш хамруулах боловсрол анги танхимаар хязгаарлагдахгүй	6
Тэгш хүртээмжтэй боловсролд багшийн заах арга зүй чухал	8
Эцэг эхийн оролцоог дэмжих нь сурлагын амжилт ахихад нөлөөтэй	10
Мэдлэгийн богц малчны хотонд	11
Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд амжилтын дэвтрийн үзүүлэх нөлөө	13
Тэгш эрх- оролцоо	14
Нэг сандал нэг хүний амьдралыг өөрчлөх хүчтэй	15
Жишиг тогтоосон сургууль	17
Тусгай ангиас энгийн анги руу	19
Дотуур байр бол бидний хоёрдах гэр билээ	21
Сургуульдаа явах зам аюулгүй байгаасай	22
Хүүхэд хамгаалал – Гараас гарт	23

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГААС

Суурь боловсрол олж авахад тулгардаг саад тотгор	26
Анги танхимаас гадуур хүрч ажиллах	30
“Хэцүү” хүүхэдтэй хэрхэн ажиллах вэ?	32
Сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал	36
Тусгай хэрэгцээт хүүхдийн ариун цэврийн өрөө	39
Аюулгүй байдлаа хадгалах нь	40
ЛБТИК гэр бүлийн дуу хоолой	42
Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажиллах нь	
Сурагч нэг бүрт тохирсон дэмжих стратеги боломжтой юу?	49
Урьдчилан сэргийлэх механизм хамгийн үр дүнтэй	52

УИХ.МН
СҮДАЛГААНЫ САН

ӨМНӨХ ҮГ

Багшийн ажил амаргүй. Өдөр тутам нэг хэвийн ажил, үүрэг гүйцэтгэдэггүй. Сурагчдаа амжилттай сургах, сайн хүн болгон төлөвшүүлэхийн тулд шинэ зүйлсийг сэдэж, туршиж, үр нөлөөг үнэлж, сайжруулж байдаг. Энэ үйл явцад сайн туршлага төрдөг. Тухайн нөхцөл, орчинд хамгийн сайн таарч байгаа практикийг сайн туршлага гэж тодорхойлдог.

Боловсролд хүүхдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, тэгш хамруулах, боловсролын орчинд хүүхэд хамгааллын тогтолцоог суулгах зэрэг шинэлэг үзэл санаанууд хууль, журманд тусч практикт нэвтрэх үе шатандаа байна. Бодлого, санхүүжилтийн дэмжлэг дутмагаас бидний, эцэг эхийн, нийгмийн хүлээлтэд нийцэхгүй байгааг бид харж шүүмжилж суухын оронд өөрсдийн хувь нэмрийг оруулахаар санаачилга гаргасан юм.

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн гишүүд, орон нутагт байгаа салбар зөвлөлүүд, Сургуулийн эцэг эх, багшийн холбоод хамтран боловсролд нийгмийн маргиналчлагдсан бүлгийн хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй сургуулийн сайн туршлагыг судалж, үр дүнд нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглахуйц кейс, жишиг туршлагыг цуглуулав. Мөн бусад улс оронд бий болгосон сайн туршлагыг өөрсдийн хөрсөнд буулгаж хэрэглэх болов уу хэмээн найдан орчуулж хамтатгалаа.

Хүүхэд бүрийг төрмөл чадавхид нь тултал хөгжүүлэх, дотор нь нуугдаж байгаа эрдэнэс бүрийг илрүүлэн нээхэд туслах багшийн мэргэжлийн “мэргэн ухаан”-ыг, сургуулийн хүүхэд бүрийг тэгш хамруулах, амжилттай сургах хүчин чармайлтыг бид баримтжуулан

бусадтай нь хуваалцах, санаа өгөх, урам зориг төрүүлэх зорилготой нэгэн үйл төлөвлөн хийснээ та бүхэнд толилуулж байна.

Эдгээр сайн туршлагыг цуглуулах үйлсэд гар бие оролцсон Хөвсгөл аймгийн Салбар зөвлөл, Багануур дүүргийн салбар зөвлөл, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 4-р сургуулийн СЭЭБХ, Буянт сумын СЭЭБХ, Булган аймгийн Булган сумын СЭЭБХ, Бугат сумын СЭЭБХ, Өвөрхангай аймгийн Хархорин сумын СЭЭБХ, Арвайхээр сумын 2-р сургуулийн СЭЭБХ, Сүхбаатар аймгийн Наран сумын СЭЭБХ, Увс аймгийн Зүүнговь сумын СЭЭБХ, Ховд аймгийн Алтай сумын СЭЭБХ-дод талархаж байгаагаа Боловсрол эвслийн Удирдах зөвлөл, гишүүдийн нэрийн өмнөөс илэрхийлье!

Тэгш хамруулан сургах тогтолцоо нь хүүхэд боловсролын тогтолцоонд зохицохоос илүү боловсролын тогтолцоо хүүхдэд зохицохыг баталгаажуулахын тулд боловсрол, орон нутгийн, сургуулийн түвшинд өөрчлөлтийг дэмждэг. Иймээс бидний энэ өчүүхэн хувь нэмэр хувь сурагчдын ялгаатай хэрэгцээнд мэдрэг хандах, сургалтын үйл ажиллагааг тохируулах, суралцах, хөгжих боломжид тулгарч байгаа саад тотгорыг арилгахын тулд сургууль дахь соёл, бодлого, практик үйл ажиллагааг өөрчлөх санал санаачилгыг өдөөнө гэдэгт найдаж байна.

“Бүх нийт боловсролын төлөө!”

*Иргэний нийгмийн үндэсний эвслийн
Ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг*

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

МОНГОЛ УЛСАД БИЙ БОЛЖ БУЙ САЙН ТУРШЛАГА

*(Орон нутгийн ерөнхий боловсролын
сургуулиудын туршлагад суурилав)*

UJI.MN
БЭДЛГ ААНЫ САН

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ АНГИ ТАНХИМААР ХЯЗГААРЛАГДАХГҮЙ

Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын IV сургууль

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Ерөнхий боловсролын IV сургуульд 2019-2020 оны хичээлийн жилд нийт 1296 суралцагч¹ суралцсанаас 17 нь хөгжлийн бэрхшээлтэй байжээ.

Сургуулиас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургахад анхаарч, Норвегийн хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын оролцоог ханган, “Дэлхийн Зөн” олон улсын байгууллагатай хамтран ажиллаж буй ажээ. Аймгийн Боловсрол Соёл Урлагийн газраас (цаашид “БСУГ” гэх) ерөнхий боловсролын сургуулиудад ирүүлсэн албан бичгийн дагуу Дэмжих багийг² байгуулж, тэгш хамруулан сургах чиглэлээр сургуулийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулан багш нарын хурлаар хэлэлцүүлэн баталжээ. Түүнчлэн БСУГ-ын мэргэжилтний

- 1 Үүнээс 571 нь эмэгтэй, 725 нь эрэгтэй.
- 2 БСШУЯ-ны сайдын А/292 тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг Ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”-ын 3.5.1-д зааснаар Дэмжлэгийн баг нь хүүхдийг сургуулийн орчинд дасан зохицоход туслах, тэдний хөгжлийн онцлог, давуу тал, сурч боловсрох, хөгжих хэрэгцээний судалгаа хийх, багш, эцэг эх, асран хамгаалагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад арга зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах чиг үүрэгтэй.

өгсөн зөвлөмжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах ганцаарчилсан хөтөлбөрийг боловсруулжээ. Энэ дагуу таван багш тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтанд хамрагдан, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ажиллаж байна.

2019-2020 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын тав нь ганцаарчилсан, үлдсэн нь үндсэн хөтөлбөрөөр хичээллэжээ. Эл сурагчдын тал нь сургуулийн гар зураг, домбор, бүжиг, ширээний теннис, даамны дугуйланд хамрагдсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцахад сургуулийн орчин, анги танхимын байрлал, тэр дундаа ариун цэврийн өрөө чухал нөлөөтэй. Сургуулиас нэгдүгээр давхарт тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхэдтэй ангийг хичээллүүлэхийн хамт эмэгтэй, эрэгтэй бие засах өрөөг шинээр тохижуулсан юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нэмэлт дугуйлана хамрагдсанаар амжилт гаргах боломжтой нь харагдаж байгаа. Манай ангийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үе тэнгийнхэнтэйгээ суралцаж, спортоор хичээллэж амжилт гаргаж буйдаа илүү сэтгэл хангалуун болж, өөрөөрөө бахархах, үнэлэх нь нэмэгдсэн.

Багш нартай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

Мэргэжлийн багш, анги удирдсан багш нар эцэг, эхчүүдэд мэдээлэл өгч, зөвлөн туслах, улмаар тэдний оролцоотой нийт сурагчдад хүүхдийн эрх, хүний ялгаатай байдал зэрэг агуулга бүхий сургалт зохион байгуулах зэргээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа суралцах боломж бий болгохоор ажиллаж байна.

Тус сургуулийн багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд урам зориг өгөх, тэднийг хөгжүүлэх, чадавхжуулах зорилгоор сайн туршлага хэрэгжүүлэх, түгээх, бусдын туршлагаас суралцах сонирхол, сэдэл байна. Үүнд дэм болж сургууль тэгш хамруулан сургах чиглэлийг дэмжин сургуулийн дотоод журамд заалт оруулсан нь багш нарт тэгш хамруулан сургах чиглэлээр ажиллах эрх зүйн орчин бүрджээ. Тэгш хамруулан сургах чиглэлээр ажиллаж буй багш нарыг урамшуулах тогтолцоог бүрдүүлж эхэлж буй.

3 Эпилепс гэдэг нь тархины эсүүдийн хэт цэнэгжилтийн улмаас уналтын голомт үүсч, ухаан алдах, татах хэлбэрээр илэрдэг эмгэг юм. (Эх сурвалж: <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/epilepsy>)

Би гурван хүүхэдтэй. Том хүү минь зүүн гар, хөлний хурууны эмгэг, түнхний мултрал, эпилепсийн хүнд хэлбэрийн өвчтэй. Хүү минь энэ сургуульд найман жил суралцаж байна. Нийгмийн халамжийн сангаас өгдөг асаргааны тэтгэмж, хүүхдийн мөнгөөр амьдардаг хэдий ч хүүхдээ уралдаан тэмцээнд оролцуулах, бусад хүүхэдтэй адил боломж олгохыг эрмэлздэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургахад эцэг эхийн оролцоо, идэвх чухал гэж үздэг.

Эцэг, эхчүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

Анхаарах нэгэн зүйл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд дунд ангиас сургуулиа орхих нь түгээмэл. Тиймээс цаашид үргэлжлүүлэн суралцахад сургуулийн дэмжлэг чухал юм. Зарим багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх хандлага, ойлголт, мэдлэг хангалтгүй буйгаас тэдэнд таагүй хандах, бусадтай харьцуулах эсвэл ялгааг харгалзалгүй эн тэнцүү үзэж үнэлэх зэрэг сул тал бий. Иймд нийт багшийн энэ талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цааш үргэлжлүүлэн суралцахад боловсролын төдийгүй эрүүл мэндийн байгууллагууд хамтран ажиллах шаардлагатай багш, сургуулийн захиргаа, эцэг эхчүүд цохон тэмдэглэж байв.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛОВСРОЛД БАГШИЙН ЗААХ АРГА ЗҮЙ ЧУХАЛ

Булган аймгийн Булган сумын “Эрдмийн өргөө” цогцолбор сургууль

Булган аймгийн Булган сумын “Эрдмийн өргөө” цогцолбор сургуульд 2019-2020 оны хичээлийн жилд 1307¹ суралцагчтай байснаас хөгжлийн бэрхшээлтэй 16, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдарч буй 108 хүүхэд байжээ. Багш нарын хувьд нийт 75 багшийн 21 нь тэгш хамруулан сургах чиглэлийн сургалтанд хамрагджээ.

Бага ангийн сурагчдын зарим нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй, хэл ярианы бэрхшээлтэй, нийгэмшлийн хоцрогдолтой, харилцааны хөгжил доогуур, багштайгаа харилцах хангалттай чадваргүй, эцэг эхийн бичиг үсэгт тайлагдсан түвшин харилцан адилгүй нь багш нар т бэрхшээл учруулдаг аж.

Бага ангийн багш нар сурагчдыг тэгш хамруулах зорилгоор “Цагаан толгой” заах үеэс эхлэн монгол хэл, бичгийн хичээлд “Тайлбартай дасгал”²-ын аргыг хэрэглэж байна. Энэ аргын цөм нь хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, бие даан даалгавар гүйцэтгэх чадвар эзэмшүүлэх, аливаа асуудлыг өөрөө шийдвэрлэж сурах, олж авсан

- 1 Үүнээс 647 нь эрэгтэй, 660 нь эмэгтэй.
- 2 Монгол Улсын гавьяат багш Г.Рэнцэндоржийн боловсруулсан “Тайлбартай дасгал”-ын аргаар сүүлийн 50 гаруй жил аймгийн үе, үеийн багш нар бэлтгэгдэж, шинэ залуу багш нартаа дамжуулан, зөвлөн тусалж ажилласаар иржээ.

мэдлэгээ ашиглаж сургахад чиглэдэг. “Тайлбартай дасгал”-ын аргаар нэг хичээлийн 40 минутад нэг сурагчийг дөрвөөс таван удаа хичээлд оролцуулдаг аж.

“Тайлбартай дасгал”-ын аргыг гол төлөв хичээлийн хоцрогдолтой, маргинал бүлгийн хүүхдүүдтэй ажиллахдаа ашигладаг. Цэцэрлэгт явж байгаагүй, хараа хяналт сул, хэл ярианы хөгжил муу хүүхдүүдтэйгээ тусгай хөтөлбөр гаргаж ажилладаг бөгөөд тэдний эцэг, эх нь ихэнхдээ бичиг үсэг мэдэхгүй байх нь түгээмэл. Тэдэнд тухайн эхийн агуулгыг ярьж өгч, хүүхдээ хэрхэн зөв уншуулж сургах талаар сургалт хийдэг. Эцэг, эхчүүд хүүхдийнх нь хэл ярианы хөгжил сайжраад, хичээлдээ ахиц гаргаад эхлэхээр их урамтай болж, сургууль дээр ирэх, багштай уулзахдаа ч дуртай болчихдог.

Багш нартай хийсэн ганцаарчилсан яриллагаас

“Тайлбартай дасгал”-ын аргаар суралцсан хүүхдийн хэл ярианы чадвар сайжирч, сурлагын чанар дээшилж байсан бол энэ аргыг хэрэглэсэн багш нар хүүхэд бүрийн онцлогийг судалгаанд үндэслэн тогтоож, тохиромжтой аргыг сонгон ажиллах чадварт түлхүү суралцжээ. Харин эцэг эхчүүдийн хувьд багш болон хүүхэдтэйгээ хамтран ажиллах нь нэмэгджээ.

Би сургалтанд сууж “Тайлбартай дасгал”-ын талаар мэдэж авсан. Багш ганцаараа хүүхдэд заах бус бидэнд хүүхэдтэйгээ гэрийн нөхцөлд хэрхэн ажиллах арга зааж өгдөг. Надад багш хичээлдээ бүх хүүхдийг адил оролцуулдаг нь таалагддаг. Манай хүүхэд ном унших дуртай, өөртөө итгэлтэй, чанга дуугаар ярьдаг болсон. Энэ аргыг хэрэгжүүлэхэд бидний оролцоо их чухал санагдсан.

Эцэг, эхчүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

Дээрх аргаас гадна тус сургууль “Цүнхтэй эцэг эх” аяныг тогтмол хийж, эцэг эх сард нэг удаа хүүхдийнхээ хичээлд суудаг аж. Энэ аян нь Дэлхийн банкны санхүүжилттэй БСШУЯ-наас хэрэгжүүлсэн “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд хэрэгжсэн СЭЭБХ¹-ны тэтгэлэгт хөтөлбөр болох “Сургуулийн бүтээлч хамт олон”

1 Дэлхийн банкны санхүүжилттэй Глоб Интернэшнл Төв болон “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн хамтран хэрэгжүүлсэн “Боловсролын салбар дахь ил тод байдал, эгэх хариуцлага” (2014-2018) төслийн хүрээнд сургуулийн эцэг эх, багшийн холбоо (СЭЭБХ) 2017 онд байгуулагджээ.

бичил төслийн нэг үр дүн юм. Төсөлд нийт 60 багш, нэгээс тавдугаар ангийн 300 орчим эцэг эхчүүд хамрагдсан ба тэдэнд тэгш хамруулах боловсрол болон нийгмийн эгэх хариуцлагын талаар сургалт орж, хамтран ажиллажээ. Улмаар багш, эцэг эхийн санаачилгаар ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултуур нэмж суурилуулж, тэргэнцэртэй хүүхдэд зориулсан стандарт хаалга, шат, налуу замаа сайжруулжээ.

Онцлох нэгэн зүйл:

“Тайлбартай дасгал”-ын арга нь нэг талаас хүүхдүүд сэтгэл ханамжтай, нөгөө талаас эцэг эхийн оролцоотой байх үндэс болж байна. Багш нарт энэхүү аргыг аймагтаа төдийгүй орон даяар түгээн дэлгэрүүлэх, практикт хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлэл, сэдэл, боломж дүүрэн байна. Цаашдаа зөвхөн бага анги төдийгүй анги ахих тусам бүх хичээлд хэрэглэх нь урт хугацаанд, тогтвортой үр дүнд хүрэхэд нэмэртэй хэмээн эцэг эх, багш, сургуулийн удирдлагууд онцолж байв.

ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ НЬ СУРЛАГЫН АМЖИЛТ АХИХАД НӨЛӨӨТЭЙ

Өвөрхангай аймгийн Хархорин сумын "Орхон" цогцолбор сургууль

Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхон цогцолбор сургуульд 2019-2020 оны хичээлийн жилд 1027¹ суралцагч хичээллэснээс хөгжлийн бэрхшээлтэй ес, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн 612 хүүхэд байжээ.

Бага ангийн "Заах аргын нэгдэл"-ийн багш нар тоглоомын аргаар хүүхдэд туслах арга зүйд эцэг эхчүүдийг суралцуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй, аюулгүй орчинг бүрдүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагаа зохион байгуулжээ.

Энэхүү сургуульд Дэлхийн банкны санхүүжилттэй БСШУЯ-ны "Боловсролын чанарын шинэчлэл" төслийн хүрээнд СЭЭБХ-ны санаачлан хэрэгжүүлж буй "Хамтдаа хөгжицгөө" төсөл хэрэгжиж байна. Багш нар зорилтот бүлгийн, бага ангийн 543 сурагчийнхаа гэрээр очин, сэтгэхүй хөгжүүлэх тоглоомоор хэрхэн тоглох талаар хүүхэд төдийгүй эцэг эхэд зааж, "Ковид 19"-ийн хөл хорионы үеэрх теле хичээлийн даалгаврыг хамтарч хийх зэргээр сурагч, эцэг эхчүүдтэй тулж ажилласан нь төслийн нэг үр дүн юм.

Мөн сургуульдаа "Оюун ухааны танхим"-ыг нээсэн бөгөөд нас, насны ангилал бүхий сэтгэхүй хөгжүүлэх тоглоомоор багш, сурагч тоглонгоо хичээллэж байна. Улмаар багш, эцэг эхийн хамтын ажиллагаа сайжрах, зорилтот бүлгийн сурагчдын сурлагын чанарт ахиц гарах, сэтгэл хангалуун болох зэргээр эерэг үр дүнд хүрчээ.

1 Үүнээс 509 нь эрэгтэй, 518 нь эмэгтэй.

Манай хүүхэд оньсон тоглоомыг тоглосноор сэтгэхүй нь задарч, өмнөхөөсөө нээлттэй болж байна. Хичээлдээ их дуртай болсон. Багш, эцэг эхчүүдэд чиглэсэн сургалт хийсэн. Багш нь аяны богиод даалгавар, тоглоомыг хийн суралцагчдын гэрээр тогтмол аялуулж байна.

Эцэг, эхчүүдтэй хийсэн ганцаарчилсан яриллагаас

Мөн сургуулийн орох, гарах хаалганд налуу зам хийх, сургуулийн гаднах замыг цементлэх, ариун цэврийн нэг өрөөг тэргэнцэртэй хүүхдэд зориулан хүйсээр ялган тохижуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хичээллэдэг ангийг нэгдүгээр давхарт шилжүүлж, ангийн хаалгыг өргөсгөх зэргээр санаачлагатай ажилласан байна.

Анхаарах нэгэн зүйл

Сургуулийн дүрэм, алсын хараанд тэгш хамруулан сургах чиглэлээр тусгасан нь сайн туршлага агаад цаашдаа ололтоо бэхжүүлэн зорилтот бүлгийн хүүхдүүдийг илүү анхааран, хөгжлийн бэрхшээлтэй сурагчтай нэмэлт цагаар ажиллаж буй багш нарт урамшуулал олгох тогтолцоог бүрдүүлэх нь урт хугацаандаа амжилттай ажиллахын үндэс хэмээн багш, сургуулийн удирдлагууд хэлж байв.

МЭДЛЭГИЙН БОГЦ МАЛЧНЫ ХОТОНД

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Ерөнхий боловсролын II сургууль

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Ерөнхий боловсролын II сургуульд 2019-2020 оны хичээлийн жилд 2240¹ суралцагчтай байсны 51 нь хөгжлийн бэрхшээлтэй байжээ. Нийт 109 багшаас тэгш хамруулан сургах чиглэлээр сургалтанд хамрагдсан 33 багш байв.

Бусад сургуультай харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо олон учраас хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай анги нээж, харин хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг үе тэнгийнхэнтэй нь нэг ангид суралцуулжээ.

Бага ангийн багш нар сурагчдын монгол хэлний чадварыг сайжруулах зорилготой “Мэдлэгийн богц”² аялуулж, хөгжлийн бэрхшээлтэй болон малчин өрхийн хүүхдийн эцэг эхэд хүрч ажиллажээ. Багш нар гурван багт хуваагдан малчин өрхийн гэрт очин, “Мэдлэгийн богц”-оо танилцуулсан ба эцэг эхчүүд нааштай хандаж, хүүхдүүдийнхээ хичээлд туслах, оролцох нь нэмэгдэж байна.

1 Үүнээс 1116 нь эмэгтэй, 1096 нь эрэгтэй.

2 Дэлхийн банкны санхүүжилттэй, БСШУСЯ-наас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн СЭЭБХ-ны тэтгэлэгт хөтөлбөр.

Манай хүүхэд нэгдүгээр анги. Эцэг эхчүүд цөм л “Мэдлэгийн боги” төсөлд оролцсон. Хүүхэд маань үсгээ хурдан цээжлэх, хурдан уншиж сурсан. Ангийн багш бидэнд санаа өгч, эцэг эхчүүд багаараа “Мэдлэгийн боги”-оо баяжуулахад идэвхтэй оролцсон. Багш, эцэг эх хамтарснаар хүүхэд хичээлдээ сайжирч байна.

Эцэг эхчүүдтэй хийсэн ганцаарчилсан яриллагаас

“Мэдлэгийн богц” аргын үр дүнд багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх ойлголт, мэдлэг сайжрахын хамт сурагчдын сурлагын амжилт ахижээ. Түүнчлэн эцэг эх, багш хамтран санаачилж, багаар ажиллаж буй тул эцэг эхчүүдийн багштай хамтрах, хүүхдэдээ туслах, сургуулиас зохиож буй аливаа ажилд оролцох идэвх сайжирчээ.

ОИЯ.МН
СУДАЛГААНЫ САН

Малчин эцэг эхчүүдтэй хамтран ажиллах бэрхшээлтэй байлаа. Хамгийн ойрдоо 10-15 км-ийн зайтай нутаглаж байгаа айлд очих хэрэгтэй болдог. Оторт яваа айлд очихын тулд багадаа 80 км зам туулах хэрэгтэй болно. Отор, нүүдлийн үеэр айлууд олдохгүй, очихоор нүүгээд явсан байдаг. Гани багш ийм хол, хөдөө явж ажиллах боломж бараг байхгүй. Тиймээс бид багт хуваагдан маршрут гарган очиж ажилласан. Малчид хүүхдийнх нь ангийн багш очоод уулзахад их баярладаг. Бид энэ төслийн хүрээнд багш багшаасаа, бас эцэг эхчүүдээс суралцах гээд их зүйл мэдэж авч байна.

Багш нартай хийсэн ганиаарчилсан яриулилагаас



ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД “АМЖИЛТЫН ДЭВТЭР”-ИЙН НӨЛӨӨ

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургууль

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургуульд 2019-2020 оны хичээлийн жилд 231 суралцагч¹, 18 багштайгаар ажиллажээ. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй гурав, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхөд амьдарч буй 19 суралцагч байна.

Хүүхэд бүрийг онцлог, ялгаатай байдалд нь тулгуурлан хөгжүүлэх нь амжилтын үндэс хэмээн бага ангийн багш нар “Амжилтын дэвтэр”-ийг багш-хүүхэд-эцэг эхийн дунд нээжээ. “Амжилтын дэвтэр”-т хүүхэд бүр өөрт тохирсон, биелүүлж чадахаар төлөвшил, эрүүл мэнд, авьяас чадвар, мэдлэг чадвар гэсэн дөрвөн зорилгын хүрээнд зорилго тавьж ажиллажээ. “Амжилтын дэвтэр”-т тусгасан хүүхэд бүрийн нийтлэг зорилгоос үүдэн сургуулийн удирдлагаас эцэг эхчүүдтэй хамтран шүдний эмчид үзүүлэх, зөвлөгөө авах зэрэг эрүүл мэндийн үйлчилгээг авчээ. Хүүхэд бүрийг “Амжилтын дэвтэр”-т бичсэн зорилгодоо хүрч чадаж буй эсэхийг ангийн багш, эцэг эх хамтран үнэлдэг аж. Тодруулбал, таван шүлэг цээжлэх, дүрэмт хувцсаа зохистой өмсөх, хичээлээ таслахгүй байх зэрэг зорилго тавьсан бол биелэлтийг шалган үнэлгээ өгдөг.

Хүүхэд бүр өөрийн онцлогтоо тохируулан зорилгоо тодорхойлж сурч, түүндээ хүрэхийг зорих болсон. Тухайлбал, төлөвшилийн зорилгод өглөө бүр ус ууж хэвших, эрүүл мэндийн зорилгод шүдээ эмчлүүлэх, авьяас чадварын зорилгод гитар сурах, мэдлэг чадварын зорилгод алдаагүй зөв бичиж сурах гэх мэт. Зорилго тавьсны үр дүнд хүүхдүүд аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан тэмцээн, олимпиадад амжилт гаргасан.

Багш нартай хийсэн ганцаарчилсан яриллагаас

“Амжилтын дэвтэр”-ээ хэрхэн хөтөлж буйг эцэг эх, багш хамтран ажиглаж, үнэлж хэвшсэнээр хүүхэдтэйгээ харилцах, ойлгох ур чадварт суралцжээ. Хүүхдүүд сэтгэл ханамжтай, өөртөө итгэлтэй болж, эцэг эхийн хандлага өөрчлөгдөж, оролцоо нэмэгдсэн. Мөн багш, эцэг эх, суралцагчийн хоорондын харилцаа холбоо сайжирч, хүүхдүүд өөрийгөө таних, ирээдүйн зорилгоо тодорхойлох, тавьсан зорилгодоо хүрэх гэсэн хүсэл, зоригтой болжээ.

Тус сургууль одоогоор СЭЭБХ-той хамтран багш нарыг сургалтанд хамруулан суралцагчдын ялгаатай байдлыг ойлгох, дэмжих, онцлог байдлыг харгалзсан даалгарын санг боловсруулж байна. Түүнчлэн хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, сурлагыг сайжруулахыг сургуулийн зорилтод тусган ажиллаж буй аж.

1 Үүнээс 126 нь эмэгтэй, 108 нь эрэгтэй

ТЭГШ ЭРХ, ОРОЛЦОО

Увс аймгийн Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль

Увс аймгийн Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль 2019-2020 оны хичээлийн жилд нийт 596¹ суралцагчтайгаас хөгжлийн бэрхшээлтэй дөрөв, сургуулиас алслагдмал амьдардаг, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдарч буй гэх бүртгэлтэй 50 хүүхэд суралцдаг. Нийт 32 багшаас хүүхэд хамгааллын чиглэлээр албан сургалтанд гурван багш хамрагджээ.

Сургуулиас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулан бие махбодийн хувьд эрүүл чийрэг, сэтгэл зүйн айдас дарамтгүй, ээлтэй аюулгүй сургуулийн орчин бүрдүүлэхээр зорин ажиллаж байна. Энэ дагуу тэгш хамруулан сургах, хүүхэд хамгааллын чиглэлээрх бодлого, төлөвлөгөөг жилийн хугацаатай батлан хэрэгжүүлжээ. Энэ хүрээнд дотуур байрны орох, гарах хаалганд налуу зам, хашлага хийн, гэрэлтүүлэг нэмсэн нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад дөхөм ажил болжээ.

Сургуулийн гадна орох, гарах хаалганд налуу зам хийсэн нь хүүхдийг маань суралцахад сургуулийн зүгээс үзүүлж буй том дэмжлэг юм. Сургуулийн нийгмийн ажилтан, СЭЭБХ хамтарч хүүхдүүдэд хүүхдийн хүмүүжлийн эерэг арга хэлбэр зэрэг сургалт явуулдаг. Тэр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй үе тэнгийн найзууд нь харьцах нэгнээ ойлгоход их түлхэц болсон.

Эцэг эхчүүдтэй хийсэн ганцаарчилсан яриулагаас

1 Үүнээс 283 нь эмэгтэй, 313 нь эрэгтэй.

Сургуулийн нийгмийн ажилтан давхар Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүнээр ажиллахын сацуу бусад багш нарын уламжлалт сөрөг ойлголт, хандлагыг өөрчлөхөд анхаарч байна. Түүнчлэн сургуулиас суралцагчдын эерэг хандлагыг төлөвшүүлэхэд анхаарал хандуулан сургуулийн удирдлага, Заах аргын нэгдэл, СЭЭБХ-ноос хамтран “Хүүхдийн чуулга” уулзалт зохион байгуулж, сурагчдын дүрэм баталжээ. Мөн тэгш хамран суралцуулах чиглэлээр “Мэдлэгийн богц” аялуулах, эцэг эхчүүдэд сургалт явуулах, эцэг эхчүүдийг сургуулийн үйл ажиллагаанд татан оролцуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан. Эцэг эхчүүдтэй хамтран ажилласнаар багш нарын ур чадвар нэмэгдэж, эмзэг, эрсдэлт нөхцөлд амьдарч буй болон хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сургалтын амжилт сайжирсан төдийгүй бусдыгаа хүндлэх, хувийн хүсэл тэмүүлэлтэй болох, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж чадсан байна.

Тэгш хамруулан сургах чиглэлийн сургалт, үйл ажиллагаанд хамрагдсанаар би хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, идэвх санаачлагатай болгох, өөрийгөө илэрхийлэх чадварыг хэрхэн дээшлүүлэхэд суралцсан.

Багш нартай хийсэн ганцаарчилсан яриулагаас

Онцлох нэгэн зүйл:

Тус сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багшийг урамшуулах тогтолцоо нэвтэрсэн агаад сургуулийн удирдлага, багш, эцэг эхчүүд цаашдаа үргэлжлүүлэх сонирхолтой байна.

НЭГ САНДАЛ НЭГ ХҮНИЙ АМЬДРАЛ ӨӨРЧЛӨХ ХҮЧТЭЙ

Ховд аймгийн Алтай сумын Ерөнхий боловсролын сургууль

Ховд аймгийн Алтай сумын Ерөнхий боловсролын сургууль 2019–2020 оны хичээлийн жилд нийт 678¹ суралцагчтай хичээллэснээс хөгжлийн бэрхшээлтэй 11 (тулгуур эрхтний, дауны, аутизмын хүрээний эмгэг, сонсголын зэрэг) суралцагч, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхөд амьдарч буй 50 хүүхэд суралцжээ. Нийт 33 багш ажилладагаас тэгш хамруулан сургах чиглэлийн сургалтанд хоёр багш хамрагджээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах, сурах боломж, нөхцлөөр хангахад ихээхэн анхаарч ажилладаг бөгөөд багш, эцэг эх, суралцагчдын энэ талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бий болгоход чиглэсэн сургалтыг сургуулиас болон СЭЭБХ-ноос удаа дараа зохион байгуулжээ. Одоо сургуулийн багш, эцэг эх, суралцагчид хамтран ялгаварлан гадуурхлаас ангид, ээлтэй орчин бүрдүүлэхээр хамтран ажиллаж байна.

Энэ сургуульд хүнд хэлбэрийн тулгуур эрхтний бэрхшээлтэй (хоёр гар нь мэдээгүй, явж чаддаггүй, хөлийнхөө хуруугаар бичдэг) нэгэн хүүхэд суралцдаг агаад хөгжлийн бэрхшээлд нь тохирсон тэргэнцэр байдаггүй тул эцэг эх нь байнга тэвэрч, хичээлд нь хүргэж өгч авдаг аж. Хүүхдийн хувьд хэл яриа, оюун ухааны чадвар хэвийн, ангидаа онц суралцдаг юм. Гэсэн ч тэргэнцэр болон сурагчийн ширээ сандалд суух боломжгүй тул сургуулиас зөвхөн түүнд тохирсон хичээлийн ширээ, сандал хийж өгсөн байна. Үүний үр дүнд хүүхдийн суралцах идэвх нэмэгдээд зогсохгүй ангийн багшийн

мэдлэг, ур чадвар, хандлага эрс сайжирчээ. Түүнчлэн сургуулийн нийт багш, суралцагчдад хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг хандлага бий болж, эцэг эхчүүдийн хамтран ажиллах урам зориг нэмэгдсэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурахад сэтгэл зүйн таатай уур амьсгал бүрдэж байна.

Манай хүүхэд багаасаа цэцэрлэгт явья гэж их гуйдаг байсан. Харамсалтай нь цэцэрлэг ийм хүүхдийг авдаггүй юм байна билээ. Харин сургууль авдагт их баярласан. Хүүхдийн минь гар мэдээгүй тул хөлөөрөө бичдэг. Багш нь энэ нөхцөл байдлыг ойлгон хамгийн урд суулгадаг. Хөлөөрөө бичихэд сургуулийн ширээ сандал тохиромжгүй байсан. Тэгсэн чинь сургуулийн зүгээс хүүхдэд маань таарсан ширээ сандал хийж өгсөн. Энэ явдал манай гэр бүлийг маш их баярлуулсан. Одоо манай хүүхэд аз жаргалтай, урам зоригтой байна. Сургуулийн орчин нөхцөл, ангийхан нь таатай болохоор хүүхэд илүү их сурах хүсэл эрмэлзэлтэй болдог юм билээ.

Эцэг эхтэй хийсэн ганцаарчилсан яриллагаас

1 (үүнээс 368 эмэгтэй, 310 эрэгтэй)-

Сургуулийн зүгээс тэгш хамран сургах чиглэлээр багш нарын үе шаттай сургалтад хамруулж, үр дүнтэй ажилласан багш нар сургуулийн төсвөөс таван хувийн нэмэгдлийг гурван багшид олгожээ. Ингэхийн хамт сумынхаа засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийг эрх тэгш, тэгш хамран сургах чиглэлээр үйл ажиллагаа тусгуулахаар ихээхэн хүчин чармайлт гаргаж байна.

Анхаарах нэгэн зүйл

Одоогоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан налуу шат, зориулалтын ариун цэврийн өрөө байхгүй аж. Шинээр баригдаж буй сургуулийн зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөө тусгуулахаар санал хүргүүлжээ. Мөн ахлах ангийн сурагчид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг шоолох хандлага ажиглагдсан тул нийт суралцагчдад нөлөөллийн ажлыг зохион байгуулах хэрэгтэй байгаагаа сургуулийн удирдагын төлөөлөл ярьж байлаа.



ЖИШИГ ТОГТООСОН СУРГУУЛЬ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын “XXI зуун” ерөнхий боловсролын сургууль

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын “XXI зуун” ерөнхий боловсролын сургууль 2019–2020 оны хичээлийн жилд нийт 735 суралцагчтай, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 25 хүүхэд (хэл яриа, сонсгол, харааны болон тулгуур эрхтний, оношоо тодорхойлуулах шаардлагатай) суралцаж байна. Тус сургуульд 50 багш ажилладаг бөгөөд ихэнх багш нар эрх тэгш, тэгш хамран сургах чиглэлээр сургалтанд хамрагдсан аж.

Тус сургууль 2014 оноос НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF) болон Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Тэгш хамруулан сургах” төсөлд хамрагджээ. 2017 оноос “Жайка” олон улсын байгууллагатай хамтран хоёр жилийн хугацаатай “тэгш хамруулан сургах төсөл хэрэгжүүлсэн байна.

Сургуулийн стратеги, жилийн ажлын төлөвлөгөөнд тэгш хамран сургах, хүүхэд бүрийн онцлогийг харгалзан хөгжүүлэх асуудлыг тусгадаг. Сургуулийн дэргэд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан төв” байгуулсан ба хүүхдүүд хуваарийн дагуу тусгай хэрэгцээт боловсролын багштайгаа ганцаарчлан ажиллаж, сургалтанд сууж, бусад үед ердийн ангид хамран суралцдаг юм. Төвийн дэргэд хүүхдийг чийрэгжүүлэх хөлний массажны аппарат, гүйлтийн зам, хөл, гар болон сарвууны булчин хөгжүүлэх аппаратыг эмчилгээний багш хариуцан ажиллуулж байна.

Эдгээр санаачлагын үр дүнд багш, сурагчдын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдлэг, хандлага өөрчлөгдөж, багш нар хүүхэд бүрийн онцлогийг харгалзан үзэх арга зүйд суралцаж, бусад сурагчид дэмжих, туслах эрмэлзэлтэй болсоор байна.

Манай сургууль 2018-2019 оны хичээлийн жилд ХНХЯ-ны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ээлтэй байгууллагаар шалгарсан. Сургуулийн дэргэд “Төв” байгуулагдахад сонсголын бэрхшээлтэй хоёр хүүхэд ирсэн. Тэд маань ангиасаа, найз нөхдөөсөө хөндийрөөгүй. Ангийхан нь анхан шатны дохионы хэлтэй болоод төгссөн. Дараа нь саажилттай хүүхэд ирсэн. Тэр маань нэмэлтээр англи хэл үзэх дуртай байсан учир манай сургууль Энхтайвны корпуссаас цагаар багш авч англи хэл заалгасан.

Багш нартай хийсэн ганцаарчилсан яриллагаас

Тэргэнцэртэй хүүхдүүдэд зориулсан налуу зам хийж, ариун цэврийн өрөөнд тусгай бариул байрлуулжээ. Анги удирдсан багш нар тухайн хүүхдийн онцлогт тохирсон тохируулгат хэрэглэгдэхүүнийг ашиглаж сурчээ. Тухайлбал, багш нар харааны бэрхшээлтэй хүүхдэд аль болох тодоор бичиж өгөх, сонсгол муутай хүүхдүүдийг урд эгнээнд суулгах, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн ангийн багш дохионы анхан шатны сургалтад хамрагдаж хүүхэдтэй харилцдаг болсон аж. Дохионы хэлийг сургуульд ажиллах дохионы хэлний багш заах ба энэ багшийн болоод бусад тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах багш нарын цалин, урамшууллыг сургуулийн төсөвт суулган шийджээ. Сургуулийн захирал, эмч, нийгмийн ажилтан, анги удирдсан багшийн бүрэлдэхүүнтэй сургуулийн “Дэмжлэгийн баг” ажиллах ба хүүхэд бүрт зориулсан ганцаарчилсан төлөвлөгөөг гарган ажилладаг бөгөөд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг үнэлэн цаашид жирийн ангид эсвэл Төвдөө сургах эсэхийг багийн хурлаар шийддэг.

Миний хүүхэд харааны бэрхшээлтэй учир Улаанбаатар хотод тусгай сургуульд явж байсан. Гэрээсээ хол дотуур байранд амьдардаг учир гэрээ санадаг байлаа. Аймагт цйм сургуультай болсонд баярлаад охиноо оруулсан. Одоо Төвийн багшаар хуваарийн дагуу хичээлээ заалгадаг. Биеийн тамир, амьдрах ухааны хичээлүүддээ ганцаарчилсан хөтөлбөрөөр, харин бусад хичээлүүддээ ангийнхантайгаа хамт суралцадаг.

Эцэг эхчүүдтэй хийсэн ганцаарчилсан яриулагаас

Аажмаар зөвхөн анги даасан багш нар ч биш бусад хичээлийн багш нарын хандлага өөрчлөгдөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах ганцаарчилсан төлөвлөгөөг хийж сурчээ. Эцэг эхчүүдийн оролцоо нэмэгдэн багш нартай хамтран ажиллах болж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурлагын чанарт ахиц гарч, сэтгэл ханамжтай, хүсэл тэмүүлэлтэй болсон.

Хүүхдийг тусгаарласнаар хичээлээс хоцорч, өөртөө итгэлгүй болдог. Харин сургууль дээр байх Төв дээр сургалтад хамруулж, бусадтайгаа хамт биеийн тамир, дуу хөгжим, англи хэлний хичээлд суралцуулснаар хүүхдэд “Би бусдаас хоцрохгүй” гэсэн сэтгэгдэл төрүүлдэгээрээ ач холбогдолтой.

Багш нартай хийсэн ганцаарчилсан яриулагаас

Анхаарах нэгэн зүйл

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг амжилттай тэгш хамруулан сургаж байгаа сургууль гэлээ ч зарим сургалтын хэрэглэгдэхүүн дутагдалтай байна. Жишээ нь, харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан брайл үсгийн ном, сурах бичиг олдоц муутай. Ахлах ангийн сурагчид англи хэл сурах эрмэлзлэлтэй учир брайл үсгээрх гадаад хэлний ном хэрэгтэй талаар багш нар удаа дараа дурдаж байв. Мөн тэгш хамран сургах чиглэлээр ажиллахын тулд цэцэрлэг, сургуулиуд багш нарын ур чадвар, хандлагад сайтар анхаарч, сайжруулах шаардлагатайг мөн дурдав.

ТУСГАЙ АНГИАС ЭНГИЙН АНГИ РУУ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын “Титэм” ерөнхий боловсролын сургууль

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын “Титэм” ерөнхий боловсролын сургуульд 2019–2020 оны хичээлийн жилд 1764 суралцагч суралцсанаас хөгжлийн бэрхшээлтэй 51, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхөд амьдарч буй 690 суралцагч байжээ. Сургуулийн 80 багш цөм эрх тэгш, тэгш хамран сургах чиглэлээр сургалтанд хамрагджээ.

Сургуульд “Хүүхдийг ивээх сан”-ийн төслөөр 2016 онд “Хүүхдийн Хөгжлийн төв” байгуулсан ба “Жайка” олон улсын байгууллагатай хамтран захирал, Заах аргын нэгдэл, эцэг эхийн төлөөллийг хамруулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй “Дэмжлэгийн зөвлөл”-ийг байгуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна. Хөнгөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энгийн ангид, хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг “Хүүхдийн Хөгжлийн төв”-д сургадаг. Сургууль болоод олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр төвийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулан иж бүрэн тохижуулжээ. Мөн ариун цэврийн өрөөнд нэмэлт суултуур, ханын бариул суулгаж, хаалганд налуу зам тавьжээ.

...Хүү маань ицээрлэгт байхдаа байнга уйлдаг, хүнээ зугтаж дөлдөг байлаа. Нэгдүгээр ангид аа өөр сургуульд элссэн байсан ч багш нь” суулгаж сургах хэрэгтэй” гээд, миний санаа маш их зовсон. Энэ сургуулийн “Хөгжлийн төв”-д хүүхдээ нийгэмшүүлэхээр явуулж эхэлсэн.

Энэ жил “Дэмжлэгийн баг”-аас энгийн ангид оруулах зөвлөмж нь гарсан. Гэхдээ өөрөө энэ анги, багшаасаа холдох дургүй байгаа. Ангидаа найз нөхөдтэй болж, багшдаа их хайртай байдаг болсон. Хүүхдийнхээ өөрчлөгдөн, олон зүйлийг сурч хөгжиж байгааг харахаар сэтгэл дүүрэн байна...

...Манай хүүхэд энэ ангид явснаас хойш их өөрчлөгдсөн. Дугуйланд яваад өөрийгөө илэрхийлж сурч байгааг нь харахад сайхан байдаг. Дуу хөгжимд дуртай учир цаашдаа энэ чиглэлээр хөгжих байх. Бусад хүүхдүүдийн хандлага ч хэдэн жилийн өмнөхөөс их өөрчлөгдөж байгаа. Багш нь ч гэсэн өөрийгөө хөгжүүлж, олон сургалтанд хамрагдаж, хүүхдээ мэдэж, мэдэрч ажиллаж байгаа.

Эцэг эхчүүдтэй хийх ганцаарчилсан яриллагаас

Сургуулийн зүгээс аймгийн Нийгмийн бодлогын хэлтсээс гаргасан тушаал, шийдвэрийн биелэлтийг хангах зорилгоор стратеги, жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигтэй тэгш хамран сургах чиглэлээр ажиллаж байгаа багш нарыг дэмжих, багшийн ажлын байрны тодорхойлолтод хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах талаар заалт оруулж, тэднийг дэмжин ажиллаж байна. Үүний үр дүнд багш нарын ур чадвар нэмэгдэх, ангийн суралцагчдын ойлголт хандлага сайжирч байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрх тэгш, тэгш хамран сургаад эхлэхээр манай багш нарын ойлголт, мэдлэг сайжирсан. Хүүхэд нийгэмшсэнээр сэтгэл ханамжтай, өөртөө итгэлтэй болсон. Эцэг эхчүүд ч бидний санаачлага, ажилд оролиож туслах болсон.

Эцэг эхчүүдтэй хийх ганиаарчилсан ярилцлагаас

Анхаарах нэгэн зүйл

Тэгш хамран сургах чиглэлээр сургуулиудыг, ялангуяа орон нутгийн ерөнхий боловсролын сургуулиудыг бодлогоор дэмжих шаардлагатай. Хэдийгээр сургуулийн зүгээс идэвх санаачлагатай ажиллаж буй ч мэргэжлийн ганц багш нь хүүхдэдээ хүрэлцэхгүй байна. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг мэргэжлийн багшийн орон тоог нэмэх шаардлага урган гарсаар байна.

ДОТУУР БАЙР БОЛ ХОЁРДАХЬ ГЭР

Баян-Өлгий аймгийн Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль

Баян-Өлгий аймгийн Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2019–2020 оны хичээлийн жилд нийт 469 суралцагчтай, 40 багштай ажилласнаас дотуур байранд амьдардаг сурагч 146 байв. Сургуулийн онцлог нь ихэвчлэн малчин өрхийн хүүхдүүд суралцдаг, сургалтаа монгол, казах хос хэлээр явуулдаг.

Сургуульд СЭЭБХ-ноос “Сайн сургуулийг дэмжих аргачлал”-ыг хэрэгжүүлэхээр сургуулийн засаглалыг орчинг үнэлэх зорилгоор баримт бичигт дүн шинжилгээ хийх, сэтгэл зүйн орчныг үнэлэх зорилгоор эцэг эх, багш, сурагч, сургуулийн удирдлагуудтай бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулан, дотуур байранд ажиглалт хийв. Судалгааны үр дүнд тулгуурлан тулгамдаж буй асуудлыг шийдэх, сайжруулах зөвлөмжийг хүргүүлсэн юм. Мөн сургуулиа хөгжүүлэх төлөвлөгөөг жил бүр боловсруулан СЭЭБХ-ны гишүүдээр хэлэлцэж даджээ.

СЭЭБХ-ноос багш, сурагч, эцэг эх, сумын иргэдэд “Хүүхэд хамгааллын тухай хууль” бусад холбогдолтой эрх зүйн баримт бичгүүдийг танилцуулж сургалт зохион байгуулсан бөгөөд сумын цагдаагийн хэлтэстэй хамтран ахлах ангийн сурагчдад сургалт, хэлэлцүүлэг хийсэн. Түүнчлэн 2017 онд Баян-Өлгий, Ховд, Увс аймгуудын нийт 11 СЭЭБХ хамруулсан баруун бүсийн “Харилцан суралцъя” чуулга уулзалт хийн, нөлөөллийн уулзалт хийх арга зүйтэй болсон.

“Сайн сургуулийг дэмжих аргачлал”-ыг хоёр жил гаруй хэрэгжүүлсний үр дүнд хөвгүүдийн дотуур байранд 40 гаруй жилийн дараа их засвар хийсэн. Сургуулийн дотуур байр өмнө нь ихэнх өрөөний хаалга эвдэрхий, цөмөрсөн, түгжээгүй, хана тааз нь нурсан, цонхны шил хагархай, чийдэнтэй өрөө бараг байхгүй, халаалтгүй учир хүйтэн байжээ. Энэ ажилд Баян-Өлгий аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 70 сая төгрөг зарцуулжээ.

Дотуур байранд амьдардаг хөвгүүд, малчин эцэг эхчүүд сэтгэл хангалуун байна. СЭЭБХ-ноос санаачлан дотуур байранд амьдардаг суралцагчдад давтлага өгөх хуваарь гарган ажилласнаар багш нарын ур чадвар нэмэгдэж охид, хөвгүүдийн сурлагын амжилтад эерэгээр нөлөөлсөн юм.

Одоогоор СЭЭБХ-ны үйл ажиллагаа тогтмолжиж, гишүүд идэвх санаачлагатай ажиллаж байна. Тухайлбал, СЭЭБХ-ноос Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгыг шинээр барих асуудлыг аймгийн нөлөөллийн уулзалтанд удаа дараа танилцуулсны үр дүнд улсын төсвөөр 2.9 тэрбум төгрөгийн өртөгтэй сургуулийн шинэ барилга барих ажил эхэлжээ.

СЭЭБХ
СУДАЛГААНЫ САН

СУРГУУЛЬДАА ЯВАХ ЗАМ АЮУЛГҮЙ БАЙГААСАЙ

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Ерөнхий боловсролын IV сургууль

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Ерөнхий боловсролын IV сургуулийн хол, алслагдмал амьдардаг өрхийн бага ангийн сурагчид хичээлдээ явган ирдгээс хичээлээсээ хоцрох, гудамжны нохойноос айх, унааны мөнгөгүй учир хичээл таслах үзэгдэл түгээмэл байжээ. Багш нар санаачлан 2019 оны 10 дугаар сараас эхлэн алслагдмал амьдрах өрхийн хүүхдүүдийг хоёр микроавтобусаар гэрээс сургуульд, сургуулиас гэрт нь зөөх болжээ. Тээврийн зардлыг багш нар болон эцэг эхийн хандив, тусламж, дэмжлэгээр эхний удаад зохицуулсан байна.

Хүүхдийн автобус явах болсноор багш бүр хуваарийн дагуу жижүүр гарган ажиллаж байна. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс автобусанд багш хамт явдаг. Автобусаар амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн болон тавиул хүүхдүүд зорчдог. Багш, эцэг эх сайн дураараа хандив цуглуулан автобусны зардлыг гаргасан.

Багш нартай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

Хүүхдүүдийн сургуульдаа ирэх, явах замыг аюулгүй болгосон учир бага ангийн суралцагчдын хичээл таслалт, агуулгын хоцрогдолт багасаж, сурлагын чанар болоод эцэг эхийн оролцоо ч нэмэгджээ.

Сургуулийн удирдлагаас сургуулийн унааг тогтмол явуулах зорилгоор 2019-2020 оны хичээлийн жилд сумын “Орон нутгийн хөгжлийн сан”-д төсөл бичин 24,700,000 төгрөгийн дэмжлэг авч сургуулийн албан ёсны микроавтобустай болжээ. Сургуулийн захирлын зөвлөлийн хурлаас хүүхдийн автобусыг 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн тогтмол явуулах шийдвэр гарчээ.

Анхаарах нэгэн зүйл

Цаашдаа сургуулийн жил бүрийн төсөвт хүүхдийн автобусны зардлыг тусгах шаардлагатай байгааг сургуулийн багш, удирдагууд хэлж байв. Сургуулийн автобусны зардлыг багш нар, эцэг эхийн халааснаас гаргах нь урт хугацаандаа сөрөг нөлөөтэй бөгөөд эргээд хүүхэд хамгаалах үйл ажиллагааг доголдуулах магадлалтай юм.

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ – ГАРААС ГАРТ

Булган аймгийн Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль

Булган аймгийн Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2019–2020 оны хичээлийн жилд 31 багш, 178 суралцагчтай, сурагчдын 63 нь дотуур байранд амьдардаг, найм нь эмзэг бүлгийнх байжээ. Өнгөрөгч онд шинэ цогцолбор сургууль ашиглалтад орсон.

Сургуулийн түвшинд Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиуд, түүнийг дагаж гарсан журмуудыг хэрэгжүүлэх үүднээс хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөөг боловсруулан, багш нараар хэлэлцүүлэн баталжээ. Энэ хүрээнд дотуур байр, анги бүрийг камержуулсан нь хүүхдийг эрсдэлт нөхцөл байдлаас сэргийлэхэд дэмжлэг болж байна. Мөн сургууль, сургуулийн орчны гэрэлтүүлгийг сайжруулан ажиллаж байна. Сургуулиас эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн хамтран ажиллаж, суралцагчдад чиглэсэн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Үе тэнгийн дарамтаас урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн хүчирхийлэл” зэрэг сургалт, сурталчилгааны материал тарааж өгчээ.

Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр сургууль өөрийн унаатай болж, дотуур байранд амьдардаг хөдөөгийн алслагдсан өрхийн суралцагчдыг улирлын амралтаар нь хүргэж өгч, авч байна. Энэ далимаараа багш нар эцэг эхчүүдтэй уулзаж ярилцан, хүүхдийн гэрийн даалгавар хийх заавар өгөх, хүүхдийг хүргэж өгөх, авахдаа хүүхэд хамгааллын хуудас бөглүүлдэг болжээ. Энэ нь дотуур байрны хүүхдүүдийн хамгааллын асуудлыг эцэг эх, хамтарсан баг, сургуулийн удирдлага гээд хамтран хэрэгжүүлж буй сайн туршлага юм. Дотуур байрны суралцагчдын нөхцөл гэртээ байдаг хүүхдүүдийнхээс

ялгаатай тул багш, ажиллагчид хамтран санаа тавьж, төлөвлөгөө гарган ажилладаг. Жишээлбэл, дотуур байрны хүүхдүүдийн хувцсыг угааж өгөх, байранд эмийн сангийн хайрцаг байршуулах, усанд орох нөхцлийг хангах зэргээр амьдрах орчны ээлтэй байдлыг хангажээ.

Харин амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхдүүдийг өдрийн хоолонд хамруулдаг. Хүүхэд хамгааллын төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас нийгмийн ажилтан, багш нарт арга зүйн дэмжлэг туслалцаа, зөвлөгөөг байнга авч ажилладаг. Өдгөө тус сургуулийн суралцагчдын хүүхэд хамгааллын талаарх ойлголт, мэдлэг дээшилж, нийгмийн ажилтан, багш нар хүүхдийг эрсдэлт нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах ур чадварт суралцан, хүүхдийн сурлагын чанарт ахиц гарсан амжилт үзүүлж байна.

Түүнчлэн сумын хүүхэд хамгааллын хамтарсан багт сургуулийн нийгмийн ажилтан ажиллах болсон нь гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдалд үнэлгээ хийх, шаардлагатай тусламж дэмжлэг, үйлчилгээг үзүүлэх чадвартай болсон.

Дотуур байрны суралцагчдыг хичээл хийх цагийг нэмэгдүүлэн байрны багш, анги удирдсан багш нар нэмэлт цаг гарган ажилласнаар охид хөвгүүдийн сурлагын чанар дээшилсэн.

Багш нартай хийсэн ганцаарчилсан яриллагаас

Сургуулийн захирал хүүхэд хамгааллын үйл ажиллагааг гардан зохион байгуулах болсон нь үүнтэй холбоотой зардал төсвийг шийдэхэд ихээхэн түлхэц болж байна.

Багш нартай хийсэн ганцаарчилсан яриллага

Анхаарах нэгэн зүйл

Энэхүү сургуулийн багш нар идэвх санаачлагатай, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагааг явуулах туршлагатай болж байна. Цаашдаа нийгмийн ажилтан, багш нарыг улам мэргэшүүлэх, бусад сургуулиудын сайн туршлагатай танилцан орон нутгийнхаа онцлогт тохируулан төлөвлөгөөг боловсруулан ажиллах шаардлагатай.



ХОЁРДУГААР БҮЛЭГ.

*ОЛОН УЛСЫН САЙН
ТУРШЛАГААС*

UJI.MN
СЭДАЛГААНЫ САН

СУУРЬ БОЛОВСРОЛ ОЛЖ АВАХАД ТУЛГАРЧ БУЙ СААД ТОТГОР

Амьдралын нэн хүнд нөхцөлд аж төрж буй хүүхдүүдийг сургуулиас завсардуулж буй үндсэн саад тотгорыг Глобал Санаачилга (Global Initiative)-ын “Сургууль завсардсан хүүхдийн судалгаа” болон бусад судалгааны үр дүнд тодорхойлон гаргасан байдаг. Үүнд:

- алслагдмал сургууль, сургуулийн дэд бүтэц муу зэрэг бодит;
- сургуулийн төлбөр, татаас, сургуульд суралцахтай холбоотой гарах зардал (ялангуяа өрхийн орлогод хувь нэмэр оруулах шаардлагаар) зэрэг санхүүгийн;
- охид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах үзэл хандлага зэрэг нийгмийн.
- саад тотгор тус тус хамаарч байна.

БОДИТ СААД ТОТГОР

Оршин сууж буй газрын ойр орчимд сургууль, анги танхим, багш-сурган хүмүүжүүлэгч хангалтгүй нь хөдөөгийн, хотын захын дүүргийн хүүхдүүдийн сургуулийн ирцэд шууд нөлөөлдөг. Охид болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай хэрэгцээнд тохирох дэд бүтэц, тохижилт байхгүй нь энэхүү бүлгийн хүүхдүүд сургуулиас завсардах эрсдэлийг нэмэгдүүлдэг.

- Бангладеш улсын том хотын захын дүүргийн хүүхдүүдийн хувьд сургуулиас завсардах эрсдэл улсын дундаж үзүүлэлтээс 2.5 дахин өндөр. (UNICEF & UIS 2014a)
- Киргизстан улсад, судалгаанд оролцсон багш нарын 63.5 хувь нь харааны бэрхшээлтэй сурагчдыг энгийн ангид суралцуулах боломжгүй (82.7 хувь нь бүрэн хараагүй сурагчдын суралцуулах огт боломжгүй) хэмээн хариулсан бол 44.2 хувь нь тэргэнцэртэй сурагчдад сургуулийн орчинг нийцүүлэх боломжгүй гэж хариулжээ. (UNICEF & UIS 2012)
- Таджикстан улсад сургууль завсардсан, эсвэл сургуулиас завсардах өндөр эрсдэлтэй охидын 18 хувь нь сургуулийн ариун цэврийн өрөө хүрэлцээгүй учраас хичээлээ тасалдаг хэмээн хариулжээ. (UNICEF & UIS 2013a)
- Вьетнам улсын зургаан аймгийг хамарсан судалгаагаар дунд сургуульд орсон ч удалгүй завсардсан сурагчид “сургууль 10 гаруй километрийн алсад оршдог, хичээлдээ явах дугуй авах, эсвэл автобусанд суух мөнгөгүйгээс сургуулиас гарсан” хэмээн хариулсан байв. (UNICEF & UIS 2014b)

САНХҮҮГИЙН СААД ТОТГОР

Эцэг эхийн санхүүгийн гачигдал нь хүүхдийг хөдөлмөр эрхлэхэд хүргэдэг бөгөөд энэ нь сургууль завсардсан хүүхдийн тоо өндөр байдаг улс орнуудад тохиолддог үндсэн саад юм. Ядуу өрхүүд сургуульд суралцахтай холбоотой гардаг шууд болон шууд бус зардлыг төлөх чадваргүй байх агаад харин ч хүүхдийнхээ олж ирэх нэмэлт орлогоос өрхийн амьжиргаа нь хамаардаг. Ийм өрхийн хүүхдүүд сургуульд суралцахаас илүүтэйгээр ямар нэг хэлбэрийн хөдөлмөр эрхлэх магадлал илүүтэй.

- Пакистан улсад нийгмийн хамгийн доод давхарга дахь өрхийн хүүхдүүд, хамгийн дээд давхарга дахь өрхийн хүүхдүүдтэй харьцуулахад сургууль завсардалт 30 хувиар өндөр. (UNICEF & UIS 2014a)
- Шри Ланка улсын сургууль завсардсан сурагчдын 19.1 хувь нь хөдөлмөр эрхэлдэг. Сургууль завсардсан хөвгүүдийн хөдөлмөр эрхлэлт (24.7 хувь) охидынхтой (11.8 хувь) харьцуулахад өндөр. (UNICEF & UIS 2013b)
- Тажикистан улсын гудамжинд хөдөлмөр эрхэлж, амьдарч байгаа хүүхдүүдийн 52.4 хувь нь сургууль завсардсан байдаг. (UNICEF & UIS 2013a)

НИЙГМИЙН СААД ТОТГОР

Угсаатны болон хэлний хувьд цөөнх иргэд болон охид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй холбоотой соёлын хэм хэмжээ, уламжлалт үзэл хандлага нь тэднийг сургуульд сурах эсэхт нөлөөлдөг.

- Энэтхэг улсад, үндэсний хэмжээнд сургууль завсардалт 3.6 хувьтай байдаг бол кастын хамгийн доод давхаргын өрхийн хүүхдүүдийн сургууль завсардах үзүүлэлт нь 5.6 хувь, кастын хамгийн доод давхаргын уугуул иргэдийн хүүхдүүдийн сургууль завсардах үзүүлэлт 5.3 хувьтай байна. Кастын хамгийн доод давхаргын охидын үзүүлэлт хамгийн өндөр нь буюу 6.1 хувьтай байв. (UNICEF & UIS 2014a)
- Киргизстан улсад хүйсээр ялгаварлах үзлийн улмаас охидын сургууль завсардалт хөвгүүдийнхээс хоёр дахин өндөр байна. Эрт гэрлэх¹ явдал нь охид сургуулиас гарах нэг шалтгаан болдог аж. (UNICEF & UIS 2012)
- Пакистан улсад төрөлх хэл нь Балучи иргэд дөрөв хүрэхгүй жилийн боловсрол эзэмших боломж 54 хувьтай бол Урду хэлээр яригсдын хувьд 11 хувьтай байдаг. (UNESCO 2010)
- Вьетнам улсад бага болон анхан дунд шатны боловсролоос завсардсан хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын хувь хэмжээ 90 хувьтай байна. (UNICEF & UIS 2014b)

1 Эрт гэрлэх буюу хүүхдийн гэрлэлт гэдэг нь нэг буюу хоёр тал нь насанд хүрээгүй байхдаа (ихэвчлэн 18 нас хүрээгүй байх) албан ёсоор гэрлэх, албан бусаар хамт амьдрахыг хэлнэ. /Эх сурвалж UNICEF “early marriage a harmful traditional practice”, 2005./

ЭЭРЭГ ҮР ДҮНТЭЙ ТУРШЛАГА

СУРГУУЛЬ ЗАВСАРДСАН ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХАНД ХҮРЧ АЖИЛЛАХ НЬ

Ази-Номхон далайн бүс нутгийн зарим улс оронд сургууль завсардсан хүүхэд, өсвөр насныханд туслах зорилгоор албан,

албан бус боловсролын аль, аль талбарт олон төрлийн стратеги, хөтөлбөрийг боловсруулжээ. Энэхүү бүс нутагт хэрэгжүүлж эхэлсэн хөтөлбөрүүдийн жишээг доор орууллаа.

Хөтөлбөр	Зорилт	Анхаарах үр дүн
Дүйцүүлсэн хөтөлбөр	Сургуульд сурах боломжгүй хүүхэд, өсвөр насныхныг албан бус сургалтын хөтөлбөрт хамруулж албан ёсны боловсролтой дүйцэхүйц боловсролын гэрчилгээ авах боломжийг олгох: <ul style="list-style-type: none"> Сургууль завсардсан хүүхдэд зориулсан Эх хэлэнд дүйцүүлэн тооцох хөтөлбөр (Непал) ; Магадлан итгэмжлэх, дүйцүүлэн тооцох хөтөлбөр (Филиппин) ; Дүйцүүлэн тооцох хөтөлбөрийн багц (А, В, С) (Индонез). 	Хэдийгээр дэлхий даяар олон төрлийн хөтөлбөр хэрэгждэг ч эдгээр санаачилгуудын чанар тааруугаас зорилтот бүлгийнхэнд үр өгөөжөө төдийлөн хүргэж чаддаггүй. Цаашилбал, ийм хөтөлбөрүүдэд мониторинг хийх үйл явц учир дутагдалтай хэвээр байна.
Бичиг үсэгт тайлагдах хөтөлбөр	Өдөр тутмын амьдралд шаардлагатай анхан шатны унших, бичих чадвар, тоо бодох, асуудал шийдвэрлэх чадварыг эзэмшихэд туслах: <ul style="list-style-type: none"> Албан бус боловсролын Бичиг үсэгт тайлагдах хөтөлбөр—Анхан шатны бичиг үсэгт тайлагдах сургалт болон Бичиг үсэгт тайлагдсаны дараах шатны сургалт (Бутан) ; А-г унших нь (Филиппин). 	
Эргэн оруулах хөтөлбөр	Бага сургуулиас завсардсан хүүхдийг эргэн сургуульд орж суралцахад туслах <ul style="list-style-type: none"> Эрчимжүүлсэн суралцахуй (А/Л) (Камбож) ; Хоёр дахь боломж хөтөлбөр (Малдив). 	
Бусад хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> “ Хөдөлгөөнт багш” хөтөлбөр (Лаос) ; “Өргөтгөсөн анги – Сонсоод суралцъя” оролцоонд тулгуурласан радио хичээлийн хөтөлбөр; Бичиг үсэгт тайлагдах, суралцахуйг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр (SPELL) (Вьетнам). 	

СААД ТОТГОРЫГ ДАВАН ТУУЛАХ АРГА ЗАМ

Сургууль завсардсан сурагчдын тооноос хамаарч боловсролыг хүртээмжтэй болгох, боловсрол олж авахад тулгарч буй саад тотгорыг арилгахаар хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа улс орон бүрт харилцан адилгүй байна. Сургууль завсардалт харьцангуй өндөр орнууд ихэвчлэн үүнийг бууруулахад чиглэсэн зорилтот үйл ажиллагаагаа бодлогын өргөн хүрээний шинэчлэлтэй тэнцвэртэйгээр

зохион байгуулах хэрэгтэй. Харин бүх нийтийн бага боловсролыг хүртээмжтэй болгохоор зорьж буй орнууд хүрч ажиллахад хамгийн хэцүү бүлгийн хүүхдүүдийг сургуулиас завсардуулж буй саад тотгорыг арилгахад зорих ёстой юм.

Зурагт боловсролыг хүүхэд бүрт хүртээмжтэй түгээхэд зориулан улс орнуудын авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, гол стратегиудыг тоймлон үзүүлэв.



АНГИ ТАНХИМААС ГАДУУР ХҮРЧ АЖИЛЛАХ

Гэрээр явж уулзах (Англи хэлний багш Дебби Полемусийн туршлага)

Калифорни мужийн Оукленд хотын Лайф Академи хэмээх улсын жижгэвтэр ахлах сургуулийн багш Дебби 20 орчим сурагчтай холимог ангийг хариуцан зөвлөгөө өгч ажилладаг аж. Тэрээр сургууль дээр зөвлөгөө өгдөг багш байхаас гадна сурагчдынхаа ахуйн орчинтой танилцан илүү дотно холбоо тогтоохын тулд сурагчдын гэрээр явж эхэлжээ. Хичээл заадаг багшаас ялгаатай нь зөвлөх багш бол сурагчдын тодорхойлолт бичих, бусад багш нараас өмгөөлж хамгаалах, өдөр бүрийг хэрхэн өнгөрөөснийг нь асууж санаа тавьдаг чухал хүн юм.

Эхний удаад Дебби шинэ элссэн дөрвөөс таван сурагчийн гэрт очиж уулзжээ. Анхандаа сурагчдын эсэргүүцэлтэй тулгарсан ч хойтонгоос нь сурагчид зөвөөр ойлгож эхэлсэн байна. Энэ нь сурагчдын итгэлтэй холбоотой байлаа. Тэрээр тулгарч асан бэрхшээлийнхээ талаар хуваалцахдаа: “Мэдээжийн хэрэг, сурагчдынхаа гэрт очих нь тэр болгон амар байгаагүй. Би нэг удаа ээж нь хурал дээр хувирамтгай, бүр дайсагнах янзтай байдаг Пейтоны гэрт очсон юм. Пейтон бага ангиасаа эхлэн олон удаа асуудалд орж байсан тул ээжтэй нь урьд хэд хэдэн удаа уулзаж байв. Түүний гэрт намайг албан ёсоор хүлээн авсан боловч биднийг дөнгөж уулзангуут Пейтоны олон дүү нь ээжийнхээ анхаарлыг татах гэж шуугилдаж эхэллээ. Сүүлийн хэдэн жилд Пейтоны үлгэр дууриал болгодог эрчүүдийн гурав нь хэрхэн бусдын гэрт амиа алдсаныг ээж нь надад ярьсан. Бодит байдал надад урьд өмнөхөөсөө илүү хүч чадалгүй болсон мэт мэдрэмж

төрүүлсэн хэдий ч, би түүний гэр бүлийн амьдралыг зэрвэсхэн ч гэсэн харсандаа баяртай байсан. Би түүний гэрт тавгүй байсан шиг, ээжид нь сургууль дээр ирэхэд мөн адил таагүй мэдрэмж төрдөг байх даа гэж би төсөөлж байлаа. Өөр үр дүн гараагүй ч энэхүү уулзалт надад Пейтон болон түүний гэр бүлийн зовлонг мэдрэх боломж олгосон юм.”

Ялангуяа “хэцүү” гэгддэг сурагчдын гэрээр очиж уулзах нь ихээхэн үр дүнтэй бөгөөд энэ талаар, “Сурагчдынхаа гэрээр явахын ач тусыг би энэ жил дахин мэдэрсэн. Учир нь манай хамгийн хэцүү сурагчдын нэг хэдэн долоо хоног сургуульдаа ирэхгүй байлаа. Сургуульдаа явахгүй байгаа учрыг олж мэдэх гэж цахим шуудангаар харилцсан боловч гэр бүлтэй нь холбогдож чадаагүй. Сурагчид ч түүний хаана байгааг, яагаад багш нарын нэг нь ч мэдэхгүй байгааг асууж эхлэв. Яг тэр үдэш түүний хичээлээс гадуурх ажлын гурван удирдагч/ментор гэрт нь хамт очиж, маргааш нь тэр хичээлдээ буцаж ирсэн юм. Гэрээр нь очсон явдал залуу хүүд илэрхий эерэг нөлөө үзүүлсний зэрэгцээ энэ нөлөө мөн сургууль даяар тархсан.” гэжээ. Энэ явдал бусад сурагчдад хамгийн их түвэг учруулдаг сурагчдын төлөө зөвхөн ангийн багш нар бус сургуулийн насанд хүрэгчид буюу удирдлагууд цөм анхаарал тавьдаг төдийгүй сургуульдаа ирэхгүй байх нь энгийн үзэгдэл биш, ямар ч асуудалтай сурагч байсан сургууль бол ээлтэй орчин гэдгийг ойлгоход тус болжээ.

СУРАГЧИЙН ГЭРЭЭР ЯВАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

Сурагчийн гэрээр явахад үр дүнд хүрч мэдэх зөвлөмж:

1

Ганц ч сурагчид ялгаварлагдсан мэт санагдуулахгүйн тулд гэрээр нь явахыг ангийнхаа эсвэл сургуулийнхаа соёлын нэг хэсэг болгоорой.

2

Өөртөө хэт ачаалал үүсгэхгүйн тулд хэний гэрээр явахаа урьдчилж журамлаарай.

3

Гэрээр явах хугацааг жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаарай.

4

Гэрээр явахдаа уян хатан хандаарай. Эцэг эх, асран хамгаалагчдад өдөр, цагийг тогтоох, сонгох боломж олгоорой.

5

Сурагчийн гаргасан амжилтын талаар нэг тодорхой жишээг гэр бүлтэй нь хуваалцахдаа үргэлж бэлэн байгаарай.

6

Сурагчийн авсан дүн, гаргасан зан авирын тухай огт ярих хэрэггүй. Энэ бол гэр бүлтэй танилцах цаг. Тэднээс нээлттэй асуугаарай.

7

Сурагчаасаа гэрийн даалгавраа гэрийнхээ хаана хийдгийг харуулахыг хүсээрэй.

8

Гэр бүлд нь гэртээ ирэхийг зөвшөөрсөнд талархал илэрхийлээрэй.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХЭЦҮҮ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ НЬ

Ангид сахилга бат тогтоох аргууд (Жастин Лим, Рөүзменд ахлах сургууль, Өмнөд Калифорни)

Худал хэлэх, хулгай хийх, зодолдох, зугатах, хараал хэлэх, бусдыг санаатайгаар гэмтээх, өшиглөх, уурсаж орилох гээд “зан төлөвийн асуудалтай” хэмээн үзсэн хүүхэдтэй өдөржин зууралдсаар байгаад багш таны тэвчээр алдагдаж байв уу? Жастин Лим багш ийм байдалд орж үзсэн ба багш нарт болон зан төлөвийн өөрчлөлттэй хүүхдэд хичээлийн жилээ үр бүтээлтэй болгоход нь туслах үүднээс зарим зөвлөмжийг хуваалцжээ.

Зан төлөв, харилцааны асуудалтай хүүхэд хэзээд байдаг, багш нар тэргүүн шугаманд зогсож өдөржингөө тэдэнтэй нүүр тулдаг. Ийм хүүхдүүд багшийг толгойныхоо үсийг зулгаахад хүргэдэг, уйлуулдаг, ажлаасаа гарах хүртэл тэвчээрийг нь бардаг. ГЭВЧ хүнд бэрх хэдий ч олон жилийн дараа таныг өөрийнхөө ажлыг хүндэтгэн үздэг нэгэн болгох, багшлах ажилд өөрийгөө зориулсан шалтгааныг тань танд сануулах хүмүүс бол чухам тэдгээр хүүхдүүд юм шүү дээ. Учир нь та энэ хүүхдүүдэд асуудлаа шийдвэрлэхэд нь тусалсан, тэднийг хайрласан нэгэн байсан гэсэн үг.


Та ангийнхаа хүүхдүүдийн зан байдлыг зохицуулахдаа хэрэглэдэг аргатай байж магадгүй. Жастин Лин багш ангидаа цаасан тавгаар хийсэн гэрлэн дохио ашигладаг байна. Энэ бол сайн зан чанарыг бататгаж, дүрэм журам эвддэг зан байдлыг илрүүлдэг арга юм.

Хүүхдүүдийн нэрсийг хувцасны хавчаар дээр бичээд ногоон тавганд хавчдаг. Дүрэм зөрчсөнийхээ дараа хүүхдүүд өөрсдийнхөө нэрийг шар гэрлэн дохио руу нүүлгэж хөдөлгөнө, өөрөөр хэлбэл, тэд үүргээ зөрчсөн тул надад 10 минутын завсарлага өгөх үүрэгтэй. Хэрвээ тэд улаан гэрэл рүү нүүвэл надад 20 минутын завсарлага өгөх үүрэгтэй ба гэр рүүгээ санамж бичиг авч явна.

Ерөнхийд нь хэлэхэд, ангийн 80 орчим хувьд энэхүү арга сайн үйлчилдэг. Ойролцоогоор хүүхдүүдийн 10 хувь нь сургууль дээрх бүх хугацаандаа сахиусан тэнгэр мэт төгс байдаг. Тэдэнд энэ арга онцын хэрэгцээгүй. Үлдэх 10 хувийн хүүхдэд харин энэ арга төдийлөн цогц биш учраас зан байдлаа бүрэн дүүрэн зөөлрүүлэхэд хангалтгүй, нөгөө талаар тэдний зан байдал нь маш хурц тул тэдэнд илүү хурдан, онцгой үр дүнд хүрэх хөхиүлэн урамшуулах систем хэрэгтэй болдог. Тэр бэрхшээл үүсгэдэг 10 хувийн хүүхдүүдийн талаар ярилцъя.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1 <https://www.scholastic.com/teachers/contributors/bloggers/justin-lim/>



"ХЭЦҮҮ" СУРАГЧДАД ЗАН АРАНШИНГАА ЗАСАХАД ТУСЛАХЫН ТУЛД ТАНЫ ХИЙЖ БОЛОХ 10 ЗҮЙЛ.

1. Хүүхдийн талаарх нэгдсэн тайланг хянаж үзэх.

Заримдаа өмнөх багшийн үлдээсэн тэмдэглэл, хүүхдийн зан байдлын тодорхойлолт, гаргаж буй зан араншингийн шалтгаан юу болох, бусад санамж зөвлөмж бүхий хувийн нууцлалтай хавтас хэрэглэж болно.

2. Хүүхдийн өмнөх багш нартай ярилцах.

Өмнөх багш нарт нь хүүхдийн гэр бүлийн нөхцөл байдлын талаар зарим санаа бодол, мөн хүүхэдтэй ажиллахад юу нь сайн байсан талаар ашиг тустай зөвлөмж байж магадгүй.

3. Зан үйлийг баримтжуулах

Энэ нь таныг хүүхдийн зан байдлын хэв маягийг илрүүлсэн тодорхой баримттай болгохоос гадна ихэвчлэн ямар төрлийн ааш авир гаргаж буйг харах боломж олгоно.

4. Захиралтайгаа нөхцөл байдлын талаар ярилцах.

Танай ангид юу болоод байгаа, цаашид танд дэмжлэг хэрэг болж магадгүйг захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтандаа урьдчилж хэлж мэдэгдээрэй. Манай сургуулийн захирал манай ангид хичээл заах, сурагчийг ангиас хэсэг хугацаагаар гаргахаас эхлээд тус болох зөвлөгөөг сэтгэл харамгүй өгч, урам хайрладаг юм.

5. Эцэг эхтэй нь уулзах.

Хааяа эцэг эхчүүд хүүхдийн зан байдлыг засах таны томоохон холбоотон, хааяа тэд нөгөө “болохгүй” асуудлыг үүсгэж буй эх үүсвэр байдаг. Ихэвчлэн эцэг эхчүүд ТАНД болон хүүхдэдээ туслахыг хүсдэг! Тэдний тусалцаа, оролцоо бол хүүхдээ өөрийгөө хянаж сурахад туслах маш хүчирхэг хэрэгсэл юм. Гол нь харилцаа холбоо!

6. Бататгал, үр дагавар болон хөхиүлэн дэмжих талаар туйлын тууштай байх.

Эдгээр төрлийн хүүхдүүд ихэвчлэн улаан шугам давах, хил зааг зөрчих, багшийг сорихдоо үнэхээр чадварлаг байдаг. Хана шиг бат бэх байгаарай.

7. Сургуулийн захирал, зөвлөх, бусад багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг хүмүүсээс тусламж эрж утасдахад бэлэн байх.

Зарим зүйлс таны ганцаараа учрыг нь олж чадах, зохицуулах чадварын хүрээнээс хэдий нь хальсан байдаг.



8. Зан байдлын гэрээ хийх/одны хүснэгт зохиох

Эцэг эхтэй нь уулзах үедээ би “Зан байдлын гэрээ” байгуулахыг санал болгодог. Өдөр бүр гэр, сургууль хоёрын хооронд явдаг энэ цаас (гэрээ) бол үндсэндээ сурагчийн эерэг, сөрөг зан чанарыг баримтжуулахад ашиглагдах бөгөөд хүүхдүүдэд урам өгч хөхиүлэх эсвэл сөрөг үйлдээ тунгаахыг сануулдаг. Мөн “Харилцах дэвтэр”-ийг санал болгодог. Энэ нь эцэг эхчүүдээс сурагчийнхаа талаарх дараах зүйлийг мэдэж авахад ихээхэн дөхөмтэй байдаг. Үүнд:

- Өглөө хэрхэн яаж эхлэв?,
- Бүтэлгүй эсвэл зарим нэг онцгой зүйлс тохиолдсон уу?

“Харилцах дэвтэр” нь өдрийн турш сурагчдад тохиолдсон эерэг хийгээд сөрөг үйл явдал, тэдгээрийн үр дагавар, цаашдаа тухайн хүүхдийн урам зоригийг хөхиүлэн дэмжихэд туслэх мэдээлэл өгдөг. Миний хувьд, сайшаал магтаал болон эерэг, сөрөг зан чанаруудыг нь баримтжуулж бичих зэргээр дэвтрийг ашигладаг. Эцэг эхчүүд өдөр бүр “Харилцах дэвтэр”-тэй танилцан хүүхэдтэйгээ тухайн өдрийнх нь зан зан үйлийн талаар ярилцсаны дараа гарын үсгээ зурдаг. Цахим шуудангаар харилцаж болох ч, тэр нь хэдий хялбар ч гэлээ би хүүхдэд “чи өөрөө сонголт хийдэг, түүнийхээ төлөө хариуцлага хүлээдэг юм шүү!” гэсэн санааг сурагчдад ойлгуулахыг хүсдэг.

9. Урамшуулал болоод үр дагаврын талаар хэлэлцэхдээ хүүхдүүдийг оролцуулж байх.

Эерэг эсвэл сөрөг үр дагаварт хүргэдэг хүн нь хүүхдүүд өөрсдөө байдгийг тэд ойлгож байгаа эсэхийг баталгаажуулаарай. Хүүхдүүдийг урамшуулахдаа өөрсдөд нь чухал, урам өгөхүйц аргыг сонгох хэрэгтэй. Дараа нь тэд өөрийн хийж буй сонголтынхоо төлөө санаа тавьж хичээх магадлалтай. Ихэнх хүүхдүүдийн хувьд гэртээ байх нь том асуудал биш ч гэлээ ТВ, компьютер, видео тоглоомгүйгээр тэд гэрээ төсөөлөхгүй байж мэднэ. Хүүхдэд хамгийн үнэ цэнэтэй зүйл юу болохыг олж мэдээрэй.

10. Эхлээд томоохон сөрөг зан авирыг шийдвэрлэж, жижиг ааш занг үл хэрэгсэх.

Энэ маш хэцүү. Манай ангид нэг сурагч байлаа. Тэрээр бараг өдөр бүр бусад сурагчтай зодолддог тэгээд ч зогсохгүй багшийгаа өшиглөж, цохисон. Би түүний ямар ч бодолгүй чалчих, алиалах, анхаарал татах гэсэн бусад ааш занг нь хайхрахгүй байх ёстой байсан л даа. Эхлээд би түүний гар, хөл, эд зүйлсээ хянаж, хөдөлгөөнгүй байлгаж, өөрийгөө хянасан өдрүүдийг тэмдэглэсэн. Тэгээд тэр үүндээ нэлээн тууштай болж эхлэнгүүт бид тохирсон хариу үйлдэл хийхээр ажилласан юм. Хэдийгээр би түүний тал дээр маш хатуу байр суурьтай байсан ч жилийн эцэст тэр намайг чанга тэвэрсэн юм даа. Тэр намайг “хамгийн сайн багш байсан” гэж хэлээд, миний тэвчээр гаргаж байсанд, мөн түүнд өөрийгөө хянаж сурахад нь тусалсанд талархсан.

БҮХ ЮМ ЧУХАЛ, ШАГНАЛЫН 11

СТРЕССЭЭ ТАЙЛАХ, ДОТРОО ОНГОЙЛГОХ, ТАЙВШРАХ АРГА ЗАМ ОЛОХ.

Багшийн ажил бол нэг талаараа гайхалтай, нөгөө талаараа стресстэй ажил. Хэрвээ танай ангид ааш зангийн өөрчлөлттэй хүүхэд байгаа бол улам л их стресстэнэ. Нэг жил би бусад багш нараас хэрвээ манай ангид намайг 30 минут орловол оронд нь биеийн тамир, зургийн хичээл заах санал хүртэл тавьж байв. Зарим жилүүдэд биеийн тамир, зургийн ангид өөрийгөө хөгжүүлэхийн тулд орж байлаа. Хааяадаа кино үзэж эсвэл номын ертөнцөд татагдан орж өөрийгөө умартан бухимдлаа тайлж байв. Ингэснээр сэтгэлийн зовууриасаа салж дараагийн өдөрт арга барил, хандлагаа өөрчилж, эрч хүчээ сэлбэсэн хүн сургуульдаа ирж чаддаг байлаа. Та юунд тайвширч байгаагаа олж мэдэн, ядарч туйлдсан өдрөө өөрийгөө хайрлах, эмчлэх арга хэмжээ авч байгаарай.

СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

*Дөрвөн шийдэл**

АНУ-ын саяхны статистик үзүүлэлтээр жил бүр 770,000 хүүхэд бие махбод, сэтгэл зүйн болоод үл хайхрах хүчирхийллийн золиос болдог аж¹. Боловсролын салбарын ажилтнууд, сургуулиуд үүний эсрэг санаачилга гаргах чадвартай гэдэгт бүгд санал нийлдэг ч “хүүхдийг хэрхэн хамгаалах вэ?” гэдгээ тодорхойлж, хүүхдийн аюулгүй байдлыг хангахыг ял мэт санадаг. Сургуулиуд шалгалтын оноог л амжилтын үзүүлэлт болгодог тохиолдолд аливаа өөрчлөлт эхлүүлэх хэцүү. Гэтэл сурлагын чанартай эн тэнцүү анхаарал хандуулах ёстой зүйл бол хүүхдийн аюулгүй байдал, хүүхэд хамгааллын асуудал билээ.

* 2014 Committee for Children, SecondStep.org

1 Монгол Улсын тухайд Хүний эрхийн Үндэсний Комиссын “Хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлын талаарх 16 дахь илтгэл” -д дурдсанаар 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэгэн хүчирхийлэлд өртсөн ба давтамжийн хувьд бие махбодийн хүчирхийлэлд хамгийн их өртдөг ба энэ нь гэр бүл, сургуулийн орчинд хамгийн их гардаг байна. Асуулгад хамрагдсан 2 хүүхэд тутмын 1 нь амьдарч буй орчноо аюулгүй, хамгаалагдсан гэж үздэггүй бөгөөд 38.3 хувь нь сургуулийн орчноос (багш, сургуулийн атаман, нийгмийн ажилтан, дотуур байрны багшаас) хамгийн их айдаг хэмээжээ.

Судалгаанд өгүүлснээр үүнийг хийх хамгийн үр дүнтэй арга бол сургуулийн бүх ажилчид, асран хамгаалагчдыг сургах, сурагчдад хүний эрхийн ур чадварын сургалт өгөх явдал аж. Хүүхдийн аюулгүй байдал, хүүхэд хамгааллын тогтолцоо бий болгохын тулд юун түрүүнд “Хүүхэд хамгааллын цогц стратеги” боловсруулан нэвтрүүлэх бөгөөд, стратеги нь дараах бүтэцтэй байх юм. Үүнд:

Журам ба Аргачлал;

- Багш, ажилчдад зориулсан сургалт;
- Оюутан, сурагчдад зориулсан сургалт;
- Гэр бүлийн боловсрол.
- Журам ба Аргачлал

Харамсалтай нь хүүхдүүд сургууль дээрээ болон сургалтын бусад орчинд бэлгийн хүчирхийлэлд өртөх нь бий. Сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс үзүүлэх бэлгийн дарамтын асуудлыг системтэйгээр авч үзэж судлаагүй болохыг хэд хэдэн судалгааны тоймд өгүүлжээ. Хэдийгээр улсын хэмжээнд багш, сурган хүмүүжүүлэгчдийн бэлгийн зүй бус үйлдлийн талаар нэгдсэн судалгаа байдаггүй ч АНУ-ын Их Сургуулийн Эмэгтэйчүүдийн боловсролын

сангийн цуглуулсан тоо баримтаар суралцагчдын 10 хүртэл хувь нь боловсрол эзэмших хугацаандаа багш ажилчдаас бэлгийн дарамтад өртөж байсан гэсэн байна. Түүнчлэн дээрх тоо баримт нь 1991 оноос 2000 оны хооронд ойролцоогоор 290,000 суралцагч төрийн өмчит сургуулийн ажилчдын зүгээс үзүүлсэн биеийн эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн болохыг харуулж байна. Сургуулийн орчинд үр дүнтэй журам болон аргачлалыг хэрэгжүүлснээр зүй бус үйлдлээс сэргийлж болох аж.²

Мөн сургуулийн удирдлагын манлайлал нь сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн тогтвортой байдал, хүрэх амжилтанд чухал нөлөөтэй байдаг аж. Сургуулийн удирдлага “хүүхэд хамгаалал бол нэн тэргүүний чиглэл” гэсэн мессэжийг түгээж, багш, ажилчдыг сургалтаар олж авсан чадвараа амьдралд хэрэгжүүлэхэд сэдэлжүүлэх, дэмжих боломжтой.

Сургуулийн удирдлагууд өөрийн сургуульдаа тохирсон хүүхэд хамгааллын стратегийг боловсронгуй болгохын тулд одоо хэрэгжиж байгаа хүүхэд хамгааллын дүрэм журам, аргачлал, туршлагандаа үнэлгээ, дүгнэлт хийх зайлшгүй шаардлагатай.

Сургуулийн удирдлагуудад сургуулийнхаа хүүхэд хамгааллын одоо хэрэгжиж буй журам, аргачлал, туршилгаа үнэлж дүгнэхэд нь туслах чанартай сургалт нэн шаардлагатай. Чанартай сургалт нь сүүлийн үеийн судалгаа, сайн туршлагыг дэмжсэн хүүхэд хамгааллын цогц стратегийг боловсруулахад дэмжлэг болох юм. Судалгаа, сайн туршилтад тулгуурласан стратеги гэдэгт нь сургуулийн болон хүүхэд залуучуудын хөтөлбөрийн орчинд хүүхдийг хүчирхийллээс

2 Монголд энэ судалгааг Хүний эрхийн Үндэсний Комиссын дэмжлэгтэйгээр “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ хийсэн бөгөөд зөвхөн их, дээд сургуулийн орчинг онцлон үзсэн байдаг.

хамгаалах, багш ажилчдын ёс зүйн дүрмийг тогтоох, сайн дурын ажилчид болон шинэ ажилчдыг сонгон шалгаруулах журам гаргах, хүүхэд хамгааллын журам зөрчсөн ажилчдыг мэдээллэх, хариуцлага хүлээлгэх зэрэг багтана.

БАГШ АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Багш нар сургуулийн ямар ч ажилтнаас илүү сурагчидтай ойр байдаг учраас тэд шууд оролцоогоор дамжуулан сурагчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах боломж ихтэй. Багш, сургуулийн удирдлага хүүхдийн эсрэг хүчирхийллийг тайлагнаж мэдээлэх маш том үүрэг хариуцлага хүлээдэг. Хэдий тийм боловч багш, сургуулийн удирдлага энэхүү үүрэг хариуцлагаа бүрэн дүүрэн үүрэхэд нь саад болдог хэд хэдэн бэрхшээл байдаг болох нь судалгаагаар илэрчээ. Үүнд,

- Багш нар хүчирхийллийн шинж тэмдгийг ялган таних мэдлэггүй байна. Багш нар хүчирхийллийн тохиолдлыг дутуу мэдээлж байгаа нь:
 - хүчирхийллийн шинж тэмдгийн талаар хангалттай мэдэхгүй, эсвэл
 - хүчирхийллийн мэдээллийг хаана хэнд мэдүүлэх нь тодорхой бус,
 - буруу мэдээлэл өгчих вий гэсэн айдсаас үүдэлтэй болох нь судалгаагаар тогтоогджээ.

Багш нар жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сургалтад маш бага сууж буй тул хүчирхийллийн шинж тэмдгийг таних, мэдээлэх арга зүйн сургалтыг илүү олон зохион байгуулвал багш нарт ашиг тусаа өгөх нь гарцаагүй юм. Багш, ажилчдын боловсрол бол үр дүнтэй хүүхэд хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол хүчин зүйлсийн нэг билээ. Хүчирхийлэл болон үл хайхралтын суурь шинж тэмдгийг ялгаж таних сургалт нь болзошгүй хүчирхийллийг олж таних болон хүүхэд хүчирхийлэлд өртсөн эсвэл, үл хайхрагдаж

байгаа гэсэн үндэслэлтэй үед сургуулийнхаа журмын дагуу мэдүүлж сургахад багш нарыг бэлтгэх юм.

ОЮУТАН, СУРАГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Хүүхдийг бэлгийн хүчирхийллээс сэргийлэхэд ашиглагддаг хамгийн түгээмэл арга бол сургалтын хөтөлбөрт нь энэ сэдвийг оруулах явдал юм. Хүүхдүүд хүчирхийллээс сэргийлэх, хувийн аюулгүй байдлаа хамгаалах олон ур чадварт ялангуяа, бэлгийн хүчирхийлээс сэргийлэх чадварт суралцах чадамжтай гэдгийг олон судалгаа харуулсан байдаг. Тухайлбал, урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдсан оролцогчдын хувийн аюулгүй байдлаа хамгаалах мэдлэг чадварын статистик үзүүлэлт нь хяналтын бүлгийн хүүхдүүдээс өндөр байжээ. Урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн сургалтыг (загварчлах, сургуулилах, бататгах) идэвхтэй арга барилаар заавал уламжлалт сургалтаас ч илүү мэдлэг, чадвар олгож олгодог.

ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хүчин чармайлт, үйл ажиллагаанд гэр бүл, асран хамгаалагчдыг татан оролцуулах нь чухал. Гэр бүл нь хүүхэд хамгаалалд гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэд хэн нэгэн хүүхэдтэй зүй бус харьцахаас хамгийн сайн хамгаалах чадвартай. Судалгааны үр дүнгээр сургуулиуд эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдийн хүчирхийлэл, үл хайхралтын талаар боловсрол олговол тэд хүүхдийг урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээх үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлахад нь тусалж чадна гэжээ.

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХДИЙН АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨ

Бие засахад туслах-тусгай асаргаа хэрэгцээт хүүхдүүд

Аливаа сургууль бусдын тусламжтай ариун цэврийн өрөө ордог хүүхдүүдэд туслах ажилтныг томилж өгөх хэрэгтэй. Хичээл эхлэхээс өмнө сургуулиуд дээр зохион байгуулагддаг сургуулийн удирдлага, багш, үйлчилгээний албаны ажилчид, сурагчид, тэдний эцэг эх, асран хамгаалагчдаас бүрдсэн уулзалт хурал маш чухал. Хүүхэд нь ямар тусгай хэрэгцээтэй гэдгийг урьдчилан мэдэгдэж, сургуулийн зүгээс харин ямар хариу арга хэмжээ авах вэ? гэдгийг хэлэлцэн тохиролцох боломж нь энэхүү уулзалт юм. Уулзалтын үеэр тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах ажилтан, хүүхдээ сургуульд даатгах эцэг эх, хүүхэд өөрөө гээд гурван талаас харилцан зөвшилцсөн нь чухал. Магадгүй тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажиллах журам гаргах нь хэрэг болж болох юм. Урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүсэхэд жишээ нь, туслах ажилтан ажилдаа ирээгүй тохиолдолд үүсэх асуудлыг шийдвэрлэх маш уян хатан бодлого, ажиллагаатай байх хэрэгтэй. Сургуулийн удирдах зөвлөл тухайн бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байвал зохилтой.



АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨНИЙ ОСОЛ

Ялангуяа дунд ангийн түвшинд ариун цэврийн өрөөнд осол гарах явдал мэр сэр байдаг бөгөөд ийм тохиолдолд сургууль ямар арга хэмжээ авч, яаж ажиллах талаар сургууль тодорхой бодлоготой байх шаардлагатай. Жишээ нь, хүүхэд ариун цэврийн өрөөнд осолдлоо гэхэд эцэг эх, асран хамгаалагч нь хурдан ирэх боломжгүй байх магадлалтай, ийм үед хүүхдийг хараа хяналтгүй ганцааранг нь үлдээснээс үүдэх үр дагаврыг харгалзан үзэх хэрэгтэй. “Сургуулийн ажилтан хүүхдэд ойртож болохгүй” гэсэн маш тодорхой шалтгаан байхгүй л бол хүүхдийн сэтгэл гонсойх магадлалыг аль болох багасгахаар бодолцож ийм үед хариуцах ажилтан хэн байхыг тодорхойлсон арга зүй байх хэрэгтэй. Гарсан тохиолдол бүрийг бүртгээ, тэмдэглэл хөтлөн эцэг эхчүүдэд хэргийн талаар мэдэгдэж байх шаардлагатай.

АРИУН
СУДАЛГААНЫ САН

АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАДГАЛАХ НЬ

Хойд Ирландын урьдчилан сэргийлэх боловсрол

Маш олон хүүхдүүд хүчирхийллийн шинж чанартай зан үйл болоод өөрт нь заналхийлж буй хүнийг ялган таних чадваргүй байдаг ба хэнээс, хаанаас, яаж тусламж авахаа мэддэггүй. Урьдчилан сэргийлэх боловсрол олгох нь хүүхдүүдэд өөрсдийгөө хамгаалахад хэрэгтэй мэдлэг, ур чадварыг олгодог бөгөөд энэ нь хүчирхийллийг эрт олж илрүүлэхэд тустай.

Сургуулийн ажилтнууд, эцэг эхчүүдийн хувьд хүүхдүүдтэйгээ бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг эмзэг сэдвийн талаар ярилцахад хэцүү байдаг гэдгийг бид мэднэ. Энэхүү хөтөлбөр нь эцэг эхчүүд болон сургуулиудад эдгээр сэдвүүдээр хүүхдүүдтэйгээ ярилцах болон хүүхдүүдийг хүчирхийллээс ангид, аюулгүй байлгахад тусална.

ГОЛ ОЛОЛТ:

Гэр бүлийн, бэлгийн хүчирхийлэл зэрэг асуудлын талаарх хүүхдүүдийн ойлголт болон мэдлэгт асар том ялгаа байдаг. Хүүхдүүд хүчирхийлэлд өртсөнөө өөрийн итгэлтэй насанд хүрэгчид хэлэх эсэхтээ ч эргэлздэг. Багш нар ийм сэдвээр хичээл заахыг ихэвчлэн

зөвшөөрдөг ч гэлээ энэ чиглэлийн сургалт, тогтвортой туслалцаа тэдэнд хэрэгтэй.

Эцэг эхчүүд хүүхдүүддээ аюулгүй байдлаа хамгаалах талаар хичээл оруулах сонирхолтой байсан ч тэдэнтэйгээ энэхүү эмзэг асуудлын талаар хэрхэн ярилцахаа мэддэггүй. Бүх хууль зүйн болон сайн дурын салбарын байгууллагууд харин өөр хоорондоо нягт хамтран ажиллаж, үр дүнтэй урьдчилан сэргийлэх боловсролыг хөгжүүлэх хэрэгтэйг хүлээн зөвшөөрдөг.

БАГА СУРГУУЛИЙН ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГЫН НЭГ БОЛОХ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ПРАКТИКИЙГ АУДИТ ДАРААХ БАЙДЛААР ҮНЭЛЖЭЭ.

1. Сургуулиуд сурагчдад аюулгүй байдлаа хамгаалах талаарх мэдлэг олгож байсан ч илүү эмзэг сэдвүүдэд мэдлэгийн хоосон орон зай байсаар байгаа;
2. Танихгүй хүний зүгээс хүүхдэд учруулж болох эрсдлийн талаар хангалттай ач холбогдол өгч ярьдаггүй. Заах арга барил нь хүүхдүүдийн гол чадваруудыг дээд түвшинд хүртэл сайжруулах боломж олгоогүй;

1 Хойд Ирландын урьдчилан сэргийлэх боловсрол, <https://learning.nspcc.org.uk/services/keeping-safe-preventative-education-in-northern-ireland>

3. Аюулгүй байдлаа хамгаалах сургалт бага насны болон тусгай сургуульд суралцаж буй хүүхдүүдэд бараг ордоггүй.

ХЭРХЭН САЙЖРУУЛАХ ВЭ?

- Багш, ажилчид хүүхдүүдэд дээрэлхэлт болон бусад бүх төрлийн хүчирхийлэл, үл хайхруулах зэргээс өөрийгөө хэрхэн хамгаалахыг зааж сургах;
- Улирал болгоны эхэнд сургуулийн ахлагчид чуулга уулзалтад оролцож тухайн улирлын сэдвийг танилцуулна. Чуулга уулзалтын дараа багш тус бүр сурагчдын насны ангилалд тохирсон гурван хичээл заана. Хичээлдээ цахим ном, анимейшны баатрууд, түүх, хэмнэлт шүлгүүд, цагаан самбар ашиглан харилцах замаар хүүхдийг сурах үйл ажиллагаанд оролцуулна;
- Гэртээ суралцах нөхцөл бий болгохын тулд хичээл бүрийн гэрийн даалгавар нь эцэг эхчүүдийг оролцуулахад чиглэсэн байх бөгөөд гарын авлага, материал нь эцэг эхчүүдэд эмзэг сэдвээр хүүхэдтэйгээ ярихад туслахуйц тусгайлан хийгдсэн байна.

СУРГУУЛИЙН АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ, ДЭМЖЛЭГ

Энэхүү хөтөлбөр нь сургуулийн нийт хамт олны хүчин чадлыг бүрэн бэхжүүлж, сургуулийн нийт хамт олонд хамгийн эмзэг, аюулгүй байдлаа хадгалах сэдвээр заах аргын чадварыг сайжруулж, мөн хөтөлбөрийг сургуулийн амьдралын бүхий л хүрээнд нэвтрүүлнэ.

- Сургалтыг танхимаар болон цахимаар хүргэнэ;
- Хөтөлбөрийг танилцуулна, ажилтан, албан хаагч нэг бүр маш чухал үүрэг хариуцлага үүрч байгаа гэдгээ ухамсарлан бататгана;
- Урьдчилан сэргийлэх боловсролыг хэрхэн сургуулийн амьдралын бүх хүрээнд тусгаж олгох вэ? гэдгийг авч үзнэ;
- Урьдчилан сэргийлэх боловсролыг мэдээлж дамжуулах

ажилтнуудад тусална

- Ажилтнууд өөрсдийгөө бэлдэхэд тусална. Хөтөлбөрийг дамжуулахын өмнө хүүхдүүд, анги танхимыг бэлдэхэд нь тусална.

Багш, ажилчид албан бус сургалтын хөтөлбөрөөр буюу зурагт хуудас, эргэн сануулах үзүүлэн, ярианд оролцуулах, ажиглалт хийх, журам боловсруулахад хүүхдүүдийг оролцуулах тогтолцоог урамшуулах, эерэг зан үйлийг үлгэр жишээ болгох замаар аюулгүй байдлаа хамгаалах мэдээллийг түгээнэ.

ЛГБТИК+ ГЭР БҮЛИЙН ДУУ ХООЛОЙ

ХҮҮХДЭД ИЛҮҮ АЮУЛГҮЙ, ЭЭЛТЭЙ СУРАХ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ДӨРВӨН АРГА¹

Канадын Онтарио мужийн бүрэн дунд боловсролын сургуулиуд олон соёл, хэв шинжит сурагчдыг ялгаварлалгүйгээр элсүүлэх болсон ч анги танхимд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх тал дээр үргэлжлүүлэн ажилласан хэвээр байна. Багш нар хэдийгээр ЛГБТИК+² сурагчдад ээлтэй боловсролыг дэмжинэ хэмээн мэдэгддэг ч бодит амьдрал дээр хүний эрхийн энэхүү бодлогыг бүрэн гүйцэт хэрэгжүүлэн ажиллаж чаддаггүй билээ.

ТЭГВЭЛ ТЭДНИЙГ ЮУ АРАГШ ЧАНГААЖ БАЙДАГ ВЭ?

Сургалтын хөтөлбөр, заах арга зүй, суралцахуйн ухааны тэнхмийн профессор Тара Голдстейн үүнд 'Эцэг эхчүүдийн хариу үйлдлээс эмээх айдас' хэмээн хариулсан байна.

Профессор Голдстейн ЛГБТИК+ сурагчдад ээлтэй боловсролын орчин бүрдүүлэх талаар багш, сурган хүмүүжүүлэгчдэд хичээл

заадаг бөгөөд багш нар энэхүү айдсын тухай ярихдаа ихэвчлэн гетеросексуал³, сизжендер⁴ эцэг эхчүүдэд төвлөрч, уламжлалт үзэл хандлагыг баримталдаг хэмээжээ. Багш нар эдгээр эцэг эхчүүдэд хэт төвлөрснөөрөө ЛГБТИК+ болон нийгмийн энэ бүлгийг дэмждэг бусад гэр бүл, эцэг эхчүүдийн эрх ашиг, хэрэгцээ шаардлагыг мартан орхигдуулж байдаг.

Эцэг, эхчүүдийн талаар багш, сурган хүмүүжүүлэгчид иймэрхүү хязгаарлагдмал үзэл, ойлголттой байгаагийн нэг шалтгаан нь "ЛГБТИК+ гэр бүл, эцэг эхчүүдтэй уулзаж ярилцах боломж тэр бүр олдож байгаагүйтэй холбоотой байж магадгүй" юм хэмээн профессор Голдстейн үзэж байна.

Энэ байдлыг өөрчлөхөөр сэтгэл шулуудсан тэрбээр сүүлийн дөрвөн жилийг ЛГБТИК+ гэр бүлүүдийн түүхийг ил гаргаж, тэднийг бусдын өмнө гарч ирэхэд туслахад зориулжээ.

Голдстейн болон түүний магистр, докторын оюутнуудаас бүрдсэн Багийнхан 2014 оноос хойш олон соёл, хэв шинжийн ЛГБТИК+

1 <https://www.oise.utoronto.ca/oise/Home/>

2 ЛГБТИК+ гэдэг нь бэлгийн цөөнхийг хэлэх олон улсын хэвшмэл нэр томъёоны товчлол юм. Дэлгэрэнгүйг эндээс уншина уу. <https://lgbtcen-tre.mn/2019/03/28/бэлгийн-цөөнхийн-тухай-түгээмэл-ацуу/>

3 Эсрэг хүйстнээ сонирхдог байдлыг хэлнэ. <https://lgbtcen-tre.mn/2019/03/28/бэлгийн-цөөнхийн-тухай-түгээмэл-ацуу/>

4 Сизжендер гэдэг нь өөрийн хүйсээ мэдрэх мэдрэмж нь төрөхөд тэмдэглэгдсэн хүйстэй нь нийцдэг хүнийг хэлнэ. <https://lgbtcen-tre.mn/2019/03/28/бэлгийн-цөөнхийн-тухай-түгээмэл-ацуу/>

гэр бүлээс аудио болон видео хэлбэрээр, ярилцлагын аргаар судалгаа авсан байна. Судалгаанд Онтарио мужийн төсвөөс санхүүждэг бүрэн дунд сургуулиуд болон ЛГБТК+ гэр бүлүүдийн хоорондын харилцаа, ЛГБТИК+ гэр бүлүүдийн үзэж туулж буй зүйлс буюу тэд ямар асуудалтай тулгардаг, болж бүтэж байгаа зүйлс, цаашид шийдвэрлэх хэрэгтэй асуудлууд, мөн хүүхдүүддээ илүү аюулгүй, ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх чиглэлээр багш сурган хүмүүжүүлэгчидтэй тэд хэрхэн хамтран ажиллаж буй талаар ярилцжээ.

Профессор Голдстейний судалгааны багийнхан видео ярилцлагуудаараа “ЛГБТИК+ гэр бүлийн дуу хоолой”⁵ нэртэй вэбсайт бүтээн байршуулж багш, сурган хүмүүжүүлэгчдэд үзэл хандлагаа өөрчлөх сургалтын арга хэрэглэгдэхүүний бааз бүрдүүлж өгсөн байна. Сайтаа бүс нутаг, сургуулийн соёл, сургалтын хөтөлбөрийн онцлог, арьс өнгө, үндэс угсаа, уугуул иргэн гэх мэт сэдвүүдээр хайлт хийж болохуйцаар төрөлжүүлжээ. Энэхүү видео ярилцлагуудаар дамжуулан багш нар ЛГБТИК+ гэр бүлүүдтэй “уулзан танилцаж” тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг сонсох боломжтой болж буй юм.

Профессор Голдстейнээс судалгааны ажлынхаа үр дүнгийн талаар, сургууль багш нарт цаашид хэрэглэж болох чухал санаа, ололтуудаасаа хуваалцсаныг доор оруулав.

СУРГАМЖ 1. БАГШИЙН ДЭМЖЛЭГ МАШ ЧУХАЛ.

Багшаас бүх зүйл шалтгаална. Судалгааны ярилцлагуудаас дүгнэхэд тухайн нэг гэр бүлийн сургуультай холбоотой эерэг, сөрөг сэтгэгдэл нь тухайн сургууль тэдэнд хэр нээлттэй хандаж, хамтран ажиллах эрмэлзэлтэй байсантай шууд холбоотой байдаг аж. Энэ нь тухайн сургууль олон нийтийн төсвөөс санхүүждэг, католик, эсвэл хөдөөгийн, хотын, хотын захын сургууль гэдгээс хамааралгүйгээр ижил байгаа юм. ЛГБТИК+ гэр бүлд өсч буй хүүхэд залуус сургууль дээр нь ойлгож дэмжих хэн нэгэн үгүй тохиолдолд сургуулиас шахагдан гарч, завсардах өндөр эрсдэлтэй байдаг.



“Сургууль дээр хүүхдийг нь дэмждэг хэн нэгэн, эсвэл дэмжлэгийн ямар нэг хэлбэр байхгүй үед тэд хүүхдээ тухайн сургуулиас гаргаж өөр нэг сургууль руу шилжүүлдэг”, “сурагчдад аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр ЛГБТИК+ гэр бүлтэй хамтран ажиллах чадамжтай сургууль олж чадаагүйгээс хүүхдээ гэрээр сургахаар шийдсэн” хэмээн судалгаанд оролцсон эцэг эхчүүд хариулжээ.

Профессор Голдстейний судалгаанаас

5 <http://www.lgbtqfamiliespeakout.ca>

Профессор Голдстейн зөвлөхдөө, хэрэв та үр нөлөөтэй дэмжлэг үзүүлж чаддаг багш болохыг хүсвэл таны хийж чадах хамгийн чухал зүйлсийн нэг нь сонсох юм. “Амьдралынхаа тухай, сургууль дээр юу хэрэгтэй байгаа тухайгаа сурагч ярих үед багш сонсдог байх хэрэгтэй. Жишээлбэл, тухайн нэг сурагч нэрээ, жендэрт нь хамаарах төлөөний үгийг өөрчилсөн тухайгаа хэлбэл энэхүү өөрчлөлтийг нь хүндэтгэн хүлээн авах хэрэгтэй юм.”

СУРГАМЖ 2: ҮЙЛДЛЭЭР ИЛРЭЭГҮЙ ДЭМЖЛЭГ ЯМАР Ч ҮР ДҮНГҮЙ.

Дэмжигч багш болохын тулд багш та ямар нэг үйлдэл хийх ёстой. “Үйлдлээр илрээгүй дэмжлэг ямар ч үр дүнгүй. Маш олон багш өөрийгөө ЛГБТИК+ гэр бүл, сурагчдыг хүлээн зөвшөөрч, дэмждэг хэмээн тодорхойлдог. Гэвч ямар нэг байнгын, тогтвортой үйлдэл хийдэггүй бол өөрийгөө ийнхүү тодорхойлох хэрэггүй юм” хэмээн Голдстейн профессор өгүүлж байна.

Сургууль дээр цөөнхийн эрхийн чиглэлээр ажилладаг холбоо, нийгэмлэгүүд ЛГБТИК+ гэр бүл, сурагчдад илүү ээлтэй, тус сургуулийн нэг гишүүн гэдгийг нь мэдрүүлэх орчин бүрдүүлэхэд гол үүрэгтэй оролцдог. Тиймээс багш нар тухайн иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаанд оролцож сурагчдаа дэмжиж буйгаа илэрхийлж болно. Канад улс даяар явуулсан судалгааны үр дүнгээс харахад “Гэй-Стрэйт нийгэмлэг”-тэй сургуулиудад ЛГБТИК+ тэй холбоотой хүчирхийлэл, дээрэлхэлт харьцангуй бага түвшинд байдаг аж. Багш нар энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг клубуудыг дэмжсэнээр тэдний хүлээн зөвшөөрөгдөх байдлыг давхар дэмжиж буй хэрэг юм.



СУРГАМЖ 3: ЛГБТИК+ ГЭР БҮЛ, СУРАГЧДЫН ХҮСЭЛТ ШААРДЛАГААС ИЛҮҮГ ХИЙХ

ЛГБТИК+ гэр бүлүүдийн хариулж байгаагаар сургуулиуд тэдний хүсэлт, шаардлагад нийцүүлж ажиллахаар хичээдэг ч энэ нь маш олон удаагийн яриа, хэлцлийн үр дүнд биеллээ олдог аж. Хүсэлт, шаардлагад нийцүүлэн ажиллах нь хэдий чухал боловч энэ нь хэзээ ч хангалттай байж чадахгүй юм хэмээн тэд хэлж байна.

“Энэ нь ЛГБТИК+ гэр бүлүүдэд тэд яг л шийдвэрлэх ёстой асуудал болсон мэт сэтгэгдэл төрүүлдэг” гэтэл үүнийхээ оронд, ЛГБТИК+ гэр бүл, сурагчдыг сургуулийн нэг хэсэг хэмээн мэдрүүлэх соёлыг сургуулийн орчинд бий болгоосой хэмээн эцэг эхчүүд найдан хүлээж байдаг аж.

Өөр хүйсийн тодорхойлолтод шилжиж буй сурагч, эсвэл хоёр ээж, хоёр аавтай сурагчдад туслах аргаа олох гэж мунгинахын оронд сургуулиуд олон хэв шинжийн гэр бүлүүдийг хүлээн авах бодлого, түүнд зориулсан процесс, системийн бэлэн байдлыг хангаж ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүд, гэр бүлтэй ажиллах бэлтгэгдсэн багш, сурган хүмүүжүүлэгчдийг бэлтгэх хэрэгтэй юм.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“ЛГБТИК+ гэр бүл, сурагчдыг хүлээн авахаар зэхэж буй сургууль нь сургалтын орчинд зарим тохируулгыг хийх хэрэгтэй. Жишээлбэл, сонгосон хүйсийнхээ дагуу ариун цэврийн өрөө хэрэглэх, сургуулийн бичиг баримт дээр шинэ нэрээрээ бүртгүүлэх зэрэгт хүндрэл учрах ёсгүй билээ.”

“Ээж эсвэл, Аавуудын баярын өдрийг гэр бүл бүхэн ижил тэмдэглэдэг хэмээн таамаглалгүй, сурагчид, тэдний гэр бүлээс энэ өдрүүдийг хэрхэн өнгөрүүлэх хүсэлтэй байгааг эхлээд асуудаг байж болох юм”

Багш, захирлуудын хувьд нэн тэргүүнд хийж хэрэгжүүлж болох зүйл бол сургуулийн бүртгэлийн маягтыг эргэн нягталж гэр бүлийн бүтэц, хүйс, арьс өнгө, үндэс угсаа гэх мэт бүхий л тодорхойлолтыг багтаасан үг хэллэг хэрэглэж буй эсэхээ шалгаж болно. Эдгээр маягтуудад өөрчлөлт оруулж болох бөгөөд жишээлбэл, эр/эм хүйсийг заахдаа саармаг төлөөний үг хэрэглэх, мөн баталгаажуулж гарын үсэг зурах хэсэгт “эцэг, эхийн гарын үсэг” гэхийн оронд “асран хамгаалагчийн гарын үсэг” гэж болох юм.

СУРГАМЖ 4: ЛГБТИК+ ГЭР БҮЛ, СУРАГЧДЫН ТУХАЙ ОЙЛГОЛТЫГ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ХЭВШҮҮЛЭХ

ЛГБТИК+ хэмээх тодорхойлолт бүхий гэр бүл, сурагчид энэхүү байдлаа сургуулийн орчинд илчлэх эсэх дээр маш болгоомжтой шийдвэр гаргах хэрэгтэй болдог. Тэд өөрсдийг нь дэмжиж хүлээж авах эсэх дээр багш сурган хүмүүжүүлэгч, захирлуудын хандлага, үйлдлийг хянамгай ажиглаж байдаг.

Зарим эцэг эх, сурагчид бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа

илэрхийллээ илчлэх нь сургуультайгаа хамтран ажиллаж хүүхдэд эерэг таатай орчин бүрдүүлэхэд тустай хэмээн үздэг бол зарим нь ингэснээр сургуульдаа гадуурхагдаж, татгалзсан хариу авах шалтгаан болно хэмээн эмээдэг аж.

“Бэлгийн болон хүйсийн тодорхойлолоо илчлэх нь эцэг эх эсвэл сурагчийг “бусдаас өөр” гэсэн ангилалд оруулдаг бөгөөд “бусдаас өөр” байх нь сургуулийн орчинд аюулгүй байж чадах зүйл биш юм”

Сургуулийн орчинг аюулгүй болгож чадахгүй тохиолдолд, сурагчид бусдад дээрэлхүүлж, хүчирхийлүүлж, аль эсвэл “Танай ээж яагаад эрэгтэй хүүхэд шиг харагддаг юм бэ?” гэх мэт тайлбарлах шаардлагагүй, сэтгэл эмзэглүүлэхүйц асуултад хариулах хэрэгтэй болдог.

Өөрийн бэлгийн болон хүйсийн тодорхойлолоо эмзэглэх зүйлгүй илчлэх боломжтой орчин бүрдүүлэхийн тулд багш сурган хүмүүжүүлэгч, сургуулийн захирал, удирдлагууд ЛГБТИК+ хүмүүс, тэдний гэр бүлийн үнэ цэнийг хүндэтгэн хүлээн зөвшөөрөхийг сургууль, анги танхимд хэвшүүлэх хэрэгтэй юм.

“Сурагчдад маш олон төрөл, хэв шинжийн гэр бүл байдаг тухай ойлголт, мэдээлэл өгснөөр ЛГБТИК+ хүмүүс, гэр бүл бусдаас өөр, гажуу харагдахаа болино гэсэн үг” хэмээн Голдстейн профессор захиж байна.



ПАДРЕ ЖЕРОМИ СУРГУУЛИЙН САЙН ТУРШЛАГА

Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах нь

Испани улсын Алгете хотод орших Падре Жероми сургуульд гурваас 12 насны 450 хүүхэд суралцдаг. Тэдний 30-35 хувь нь сэтгэл зүй, хараа, хөдөлгөөний гэх мэт ямар нэг тусгай хэрэгцээтэй хүүхдүүд байдаг. Тус сургууль нь тусгай хэрэгцээтэй хүүхдүүд энгийн сургуульд орж суралцахыг дэмжих зорилгоор хүүхэд бүрт тохирсон сургалтын материал боловсруулж чадсан сайн туршлагын эзэн төдийгүй үр дүнтэй хамтран ажиллаж, нөөц боломжийг үр ашигтай зохион байгуулахад чиглэсэн бичиг баримтыг гаргажээ. Энэхүү туршлагын давуу тал нь:

- Багшийн сургалт, хөгжил;
- Багшийн болон бусад ажиллагсдын хандлагыг өөрчлөх;
- Нэмэлт дэмжлэг, туслалцаа, түүнийг зохион байгуулах хэв маягийг тодорхойлсонд оршино.

Тус сургууль нь 1987-1988 онуудад хэрэгжиж эхэлсэн “Боловсролын тусгай хэрэгцээтэй сурагчдыг энгийн ангид суралцахыг дэмжих” хөтөлбөрт хамрагдахаар шийдэн түүнээс хойш, тус сургууль сургалтын хөтөлбөрөө тогтмол өөрчлөн сайжруулж, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан стратеги төлөвлөгөөг тусгах болжээ. Тэрхүү стратеги төлөвлөгөөнд сургуулийн нийт ажиллагсдыг хэрхэн удирдан зохион байгуулах, мөн ялгаатай хэв шинж бүхий

сурагчдаас бүрдсэн сургалтын орчин бүрдүүлэх чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнээр сургалтын материал боловсруулуулах зэрэг ажлууд багтаж байв.

“Сургууль бүр сурагчдын боловсролд зориулсан ерөнхий төлөвлөгөөтэй байхаас гадна тусгай хэрэгцээт боловсролгох стратеги төлөвлөгөөг ч бас гаргах хэрэгтэй юм” хэмээн тус сургуулийн удирдлага үздэг аж.

Оролцоог дэмжиж боловсролын үйл ажиллагааг амжилттай зохион байгуулах үндсэн стратегид аль болох олон тооны оролцогч талуудыг хамарсан харилцан яриа өрнүүлэх үйл явц ордог. Тусгай хэрэгцээтэй сурагчидтай харилцахын тулд сургуулийн удирдлага, багш сурган хүмүүжүүлэгчид, туслах ажиллагсад, гэр бүл, эцэг эх болон сурагчид өөрсдөө энэхүү харилцан ярианд оролцоно гэсэн үг юм. Хүн бүрийн хэрэгцээ, шаардлагыг сонсох хэрэгтэйгээс гадна үйл ажиллагааны үндсэн агуулга, зарчим нь оролцогч талуудын үзэл бодол, туршлага дээр үндэслэн бий болох ёстой. Сургуулийн нийт ажиллагсад энэ дагуу хамтын итгэл үнэмшлийг бүрдүүлэх хэрэгтэй юм. Аль болох олон гишүүн оролцох тусам үр дүн нь тэр хэрээр

нэмэгдэх болно.

Оролцогч талууд өөрсдийн ур чадвартаа тулгуурлан оролцоог бий болгох үйл ажиллагаанд өөрсдийн гэсэн хувь нэмрийг оруулах хэрэгтэй билээ. Үүнд:

- **Сургууль:** Зохион байгуулалт, мэргэжлийн хүний нөөц болон эд материалын дэмжлэг үзүүлэх;
- **Сурган хүмүүжүүлэгч:** Тусгай хэрэгцээтэй сурагчдыг сургалтын үйл явцад хамруулах мөн тусгай хэрэгцээтэй сурагч нэг бүрт тохирох тэдний оюуны болон нийгмийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, заах арга зүйг боловсруулах;
- **Туслах ажилтан болон гэр бүл:** Оролцоог бий болгоход сайн үлгэр дууриалыг үзүүлэх;
- **Сурагч:** Ялгаатай байдал нь олон хэв шинжийг бүрдүүлэх үндсэн хүчин зүйл гэдгийг ойлгох.

Мэргэжлийн, уялдаа холбоотой орчныг бий болгох өөр нэгэн чухал зүйл нь тусгай хэрэгцээтэй сурагч нэг бүртэй чиглэл, чиглэлийн багш нар баг болон хамтран ажиллах явдал юм. Энэ төрлийн зохион байгуулалтын ач холбогдлыг таньж мэдсэн даруйдаа Падре Жероми сургууль өөрийн гэсэн зохион байгуулалтын арга техникийг боловсруулжээ. Үүнд:

- Багш нар тухайн тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээ нэгтгэх үүднээс хоорондоо тусгай уулзалт зохион байгуулдаг.
- Тусгай мэргэжлийн багшийн ажлыг хөнгөвчлөх үүднээс сургуулиас “Ажлын хүснэгт” боловсруулжээ. Ажлын хүснэгтэд ерөнхий болон тусгайлан боловсруулсан сургалтын хөтөлбөр хэрхэн хэрэглэгдэж буй талаар, мөн сурагч бүрийн суралцахуйн явцыг тэмдэглэн үлдээдэг аж. Жишээлбэл, хөдөлгөөний ур чадвар, хэл, унших, бичих зэрэг олон төрлийн ур чадварын талаар бүртгэх бөгөөд эдгээр чадварыг ямар нэг тусламж дэмжлэгтэйгээр эзэмшсэн эсэх талаарх мэдээллийг мөн

тэмдэглэдэг байна.

- Тусгай хэрэгцээтэй хүүхдэд шаардлагатай үед тусламж, үйлчилгээ үзүүлэх туслах ажилтан байх хэрэгтэй юм. Тодорхой хэмжээнд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зүйл боловч тусгай хэрэгцээтэй хүүхдийн оролцоог дэмжихэд, мөн сургалтын орчны хүний нөөцийг дэмжихэд нэн тустай билээ. Бүр боломжгүй тохиолдолд багш нар сурагчдыг (гурваас таван сурагч) жижиг бүлэгт хуваан даалгавар гүйцэтгүүлдэг. Нарийн мэргэшсэн багш нар (сэтгэлзүйн зөвлөх, яриагаар эмчлэгч гэх мэт)-ын хувьд туслах багш, жижиг бүлгээр ажиллуулах аль аль аргыг хослуулан хэрэглэдэг.
- Сургалтын материалын хувьд тусгай хэрэгцээтэй эсэхээс үл хамааран сургалтын хэрэглэгдэхүүнийг аль болох хол давтамжтай хэрэглэх нь зүйтэй. Сургалтын хэрэглэгдэхүүн тухайн нэг сурагчийн чадамжаас давсан үед хэрэгцээ, боломжид нь тохируулан өөрчилж болно. Багш нар хүүхэд нэг бүрт зориулсан дасгал ажлын ном хүртэл боловсруулж болно. Тухайн дасгал ажлын номыг ажилласнаар бусад хүүхдүүдтэй адил үр дүнд хүрч болох бөгөөд уг номыг тухайн сурагчийн онцлогт тохируулан боловсруулсан байхад л болох юм.
- Тусгай хэрэгцээтэй сурагчидтай ажиллаж буй багш, ажиллагсад суралцахуйн үйл ажиллагааны талаар дүгнэж ярилцах уулзалтууд зохион байгуулдаг. Тэд “тусгай үнэлгээ өгөх тайлан” боловсруулсан бөгөөд үүнийгээ сар, улирал, жил бүр шинэчилж, шалгаж явдаг ажээ. Энэхүү үнэлгээ өгөх тайланд гэр бүлээс эхлээд багш сурган хүмүүжүүлэгчид хүртэл боловсролын үйл ажиллагаанд оролцож буй хэн бүхнийг хамруулан мэдээлэл цуглуулдаг байна. Суралцахуйн үйл ажиллагааг үнэлэх үедээ илүү бодит болгох үүднээс ажиллагсад үнэлгээний тайланг сурагчдын боловсролын түвшинд тохируулах өөрчилж болдог ч үнэлгээний хувьд сурагч бүрт нэг ижил загвар ашигладаг аж.
- Сургууль тусгай хэрэгцээтэй хүүхдийн гэр бүл, эцэг эхийг тэдний суралцахуйн хамгийн эгзэгтэй цаг үед хамтран оролцуулахаар

зорьдог.

- Сургууль хүүхэдтэй нь хэрхэн ажиллаж буй талаар мэдээлэл өгөх;
 - Сурагчийн суралцахуйн үйл явцыг үнэлэх, эргэн шалгах уулзалтуудад оролцохыг урих;
 - Хичээлийн жил бүрийн төгсгөлд, ялангуяа хичээл бүрийн дараа шаардлагатай мэдээллийг өгөх зэрэг.
- Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллаж буй үйл ажиллагаа, түүнтэй холбоотой өөр бусад мэдээллийг олон нийтэд түгээхэд анхаарч ажилладаг. Ингэснээрээ тэд тусгай хэрэгцээтэй хүүхдийн боловсрол олж авах асуудал тухайн нэг гэр бүлийн үүрэх ёстой асуудал бус бүх нийтийн ашиг сонирхол болгоход өөрийн хувь нэмрийг оруулж байгаа ажээ.
- Оролцоог дэмжих сургалтын энэхүү загварыг хэрэглэснээр урт хугацааны төдийгүй өргөн хүрээний үр дүнд хүрч болдог. Үр дүнг нь боловсролын бүхий л түвшний байгууллагын оролцогч талууд төдийгүй нийгэм даяараа хүртэх боломжтой. Хүүхдэд тэгш оролцоог хангасан сургалтын орчинг бий болгож өгснөөр илүү тэгш хүртээмжтэй, эрх тэгш, дэвшилтэт нийгмийг бий болгож чадна гэсэн хатуу итгэл үнэмшлийг тус сургууль баримталдаг аж. Ингэснээрээ тус сургууль нь тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн амьдралыг өөрчлөөд зогсохгүй, нийгмийн шийдвэр гаргагч бүлгүүд, бодлого боловсруулагч талуудын сэтгэлгээ, хандлагыг оролцоог дэмжих тал дээр өөрчлөхөд нөлөөлж буй юм.

СУРАГЧ БҮРТ ТОХИРСОН СОНСОХ, ДЭМЖИХ СТРАТЕГИ БАЙХ БОЛОМЖТОЙ ЮУ?

Сургуульд хүүхдүүдийн санаа зовж буй асуудлыг анхааралдаа авч, тухайн асуудал хүчирхийллээс үүдэлтэй байна уу, эсвэл анхаарлын гадна үлдсэнээс урган гарав уу? гэдгийг ялган, таньж ажиллах тогтолцоо байх хэрэгтэй. Хүүхэд өөрсдөд нь тусламж хэрэгтэй байгааг хэлсэн л бол дахин, дахин хэлж тайлбарлаад байх шаардлагагүй, тогтолцоо өөрөө ажиллах болно.

Сурагчдын хэрэгцээ, шаардлагыг сонсох янз бүрийн тогтолцоотой сургуулиудад хийсэн хэд хэдэн судалгаагаар ийм тогтолцоо нь сурагчдад хэрэгцээтэй тусламж, дэмжлэг үзүүлдэгийг баталсан юм. Энэхүү “сурагчдыг сонсох тогтолцоо” нь насанд хүрэгчдээр удирдуулсан эсвэл сурагчдын өөрийн удирдлагын тогтолцоотой байдаг, сүүлийн үед “тоглоомын талбайн найз”, “асуудлаа хуваалцах найз”, “үе тэнгийн ментор найз” гэх мэтээр нэрших болжээ. Зөвлөгөө авсан сурагчдын олонх нь “үе тэнгийн ментор найз”-аа сонгож ярилцана гэдгээ илэрхийлж байв.

Насанд хүрэгчдээр ахлуулсан сурагчдыг сонсох, дэмжих тогтолцоог доор тодорхойллоо. Хүүхэд хамгааллын хүрээнд асуудлыг танин барих, хариу арга хэмжээг хэрхэн вэ гэдэг арга зүйг багш ажилчид болон сурагчдад зааж сургах нь хамгийн чухал юм.

АНГИЙН СОНГОЛ ДЭМЖЛЭГ

Ярих цаг – Багш, багшийн туслах эсвэл сургуулийн ажилтан тухайн ангитай цаг гарган ярилцана гэдгээ илэрхийлж буй хэрэг юм. Ингэснээр хүүхдүүд тэднийг олж уулзаж чадахгүйдээ бухимдахаас

сэргийлнэ. Мөн багш, ажилчид сурагчдыг сонсохыг хүсдэг гэсэн ойлголтыг төрүүлнэ.

Санаа зовиолын хайрцаг – Хүүхдүүд санаа зовоосон асуудлаа цаасан дээр бичээд хайрцагт хийнэ. Хүсвэл нэрээ бичихгүй байж болно. Багш нар энэхүү хайрцагт тогтмол хяналт тавьж хүүхдүүдтэйгээ ганцаарчлан уулзах буюу эсвэл ангиараа тойрон сууж ярилцах цагаар асуудлыг хэлэлцүүлнэ.

Тойрог уулзалтын цаг – Аюулгүйн дүрмийг баримталсан тогтмол уулзалтыг хэлнэ. Тойрог уулзалтын зорилго нь янз бүр байж болох бөгөөд тухайлбал, том асуудлыг дэвшүүлэн өргөнөөр хэлэлцэх, өөрсдийн мэдрэмжээ айлгүй илэрхийлэх, хэлэлцэх, нийгэмших чадвараа загварчлах, хөгжүүлэх, анги хамт олны харилцааг хөгжүүлэх гэх мэт.

Найз нөхдийн хүрээ – Багш, ажилчдын тусламжтайгаар хүүхдүүд

Аюулгүй байгаагаа мэдэрнэ гэдэг нь юу гэсэн үг вэ?

- ° Найзуудтай байна гэсэн үг. Мөн тоглоомын талбайд чамд туслах, чамайг дэмжих найзтай байна гэсэн үг.
- ° Том хүнтэй ярилцаж болно гэдгээ мэднэ гэсэн үг. Тэдэнтэй ярилцах үед бид үнэхээр аюулгүй байна гэдгээ мэдэрнэ гэсэн үг.
(Фокус бүлгийн ярилцлагын үеэр хүүхдийн хэлсэн үг)

энэхүү дэмжлэгийг авч болно. Ангид эсхүл тоглоомын талбайд үе тэнгийн найзуудаа туслаж дэмжинэ гэсэн үг.

Тусгай орон зай/ чимээгүй орчин – Хэрвээ хүүхэд анги танхимдаа эсхүл тоглоомын талбайд ирэхгүй байвал багш нар араас нь маш идэвхтэй явж хүүхэд тухайн орчинд ямар асуудал бэрхшээлтэй нүүр тулгарч байна, тэр талаараа ярихыг хүсч байна уу? гэдгийг олж мэдэх хэрэгтэй.

СУРГУУЛЬ ДАЯАР СОНСОЖ БАЙНА, ДЭМЖИЖ БАЙНА.

Сургуулийн зөвлөл – анги, ангийг төлөөлсөн бүлэг сурагчдыг хэлнэ. Тэд ангийн тойрог уулзалтын үеэр тухайн нэг асуудалд ангийнхан нь ямар байр суурьтай байсныг зөвлөлийн хурлаар илтгэнэ. Энэ нь хоёр урсгалтай мэдээлэл солилцох үйл явц бөгөөд зөвлөлд сонгогдсон сурагч хурлын үеэр яригдсан асуудлын талаар эргээд ангийнхандаа мэдэгдэх үүрэгтэй.

Дэмжлэгийн бүлэг – Зургаагаас 10 хүүхдээс бүрдсэн жижиг бүлэг байгуулах. Үйл ажиллагаа сургууль дээр явуулах агаад чиглүүлэгчтэй байна. Чиглүүлэгч нь мэргэжлийн сургалтанд хамрагдсан насанд хүрэгч байх ба энэхүү бүлэгт зөвлөн, чиглүүлж ажиллана. Дэмжлэгийн бүлэг нь богино хугацааны, тодорхой бүлэгт чиглэсэн байх бөгөөд урьдчилан сэргийлэх стратегийг баримтална. Энэхүү стратеги нь нийгмийн, сэтгэл хөдлөлийн, зан үйлийн бэрхшээлээс үүдэн суралцахуйн бэрхшээлтэй нүүр тулгарч буй сурагчид руу чиглэсэн, бүх сурагчдыг хамарсан, дэмжсэн арга барилаар ажиллана. Өөрөөр хэлбэл бүлгээр ажиллах үйл ажиллагаанд сурагчдын нийгэмших чадварыг хөгжүүлнэ. Үр дүнд хүрэхийн тулд чадварлаг мэргэжилтнүүдийн янз бүрийн арга техник ашиглаж хүүхдүүдийг дахин анги хамт олонтойгоо нийлэхэд нь тусалдаг.

Үдийн цай болон өглөөний цайны клуб – албан бус уулзалтын хэлбэр бөгөөд хэрэв хүсвэл хүүхдүүд энэхүү боломжийг ашиглан ярьж болно. Нэгэн сургууль үдийн цайны дэмжлэгийн бүлэгтэй бөгөөд хэрвээ хүүхдүүдэд дэмжлэг хэрэгтэй байвал энэхүү бүлэгт хандаж болдог.

Ганцаарчилсан зөвлөгөө – Сайн дурын байгууллагууд эсхүл орон нутгийн үйлчилгээний байгууллагаас туслалцаа авч сурагчдад ганцаарчилсан зөвлөгөө өгч болно. Хүүхдүүдийн санаа зовж буй асуудал нь өөртэй нь хамаатай, эцэг эхэд хамаарах, эсвэл багш, ажилчдад хамаарах асуудал байж болно.

Гэр бүлийн дэмжлэг – Сургуулийн эцэг эхчүүд нэгдэн уг бүлгийг ажилуулдаг. Хүүхдүүд үүнийг аюулгүй орчноо болгон ашиглаж болохоос гадна багш, ажилчидтай итгэлцэл үүсгэхдээ ашиглаж болно. Ямар ч хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болох бөгөөд тухайлбал, гэрийн даалгаврын, цэцэрлэгжүүлэлтийн клубыг ажиллуулах замаар эмзэг бүлгийн сурагчдыг албан бус байдлаар дэмжин ажилладаг. Хүнд нөхцөлд байгаа аливаа гэр бүл тус бүлэгт хандаж орон нутгийн удирдах байгууллагын харьяа агетлагуудаас дэмжлэг авахад нь тусалж болдог.

Суралцахуйн менторууд – Сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн асуудалтай хүүхдүүдтэй ажиллах нэмэлт ажилчид буюу мэргэжлийн сэтгэлзүйчид, хүний эрхийн чиглэлээр ажилладаг сайн дурынхан, мэргэжлийн ангийн оюутнууд гэх мэт хүмүүсийг хүүхэдтэй ажиллуулж болно.

САЙН ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Дээрх олон жишээнээс харахад сургууль маш олон төрлийн дэмжлэгийн тогтолцоотой байж болох бөгөөд энэхүү тогтолцоо нь сурагчдын хэрэгцээ, байр суурийг сонсож бодитоор дэмждэг. Эдгээр дэмжлэг нь эмзэг бүлгийн сурагчдад илүү чиглэсэн шууд дэмжлэг болдог.

- Дэмжлэгийн тогтолцоо нь аль болох эрт үед нь асуудлыг танин мэдэж хариу арга хэмжээ авах, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй эсхүл анхаарлын гадна үлдэх магадлалтай бүлгийн сурагчдад тухайн цаг үед нь тохирсон арга хэмжээг авах бүтэц, зохион байгуулалтай байдаг.
- Төрөл бүрийн дэмжлэгийн тогтолцоо нь бүхэлдээ сургуулийн бодлого, стратегийн нэгэн хэсэг болох бөгөөд бие, биенээ харилцан нөхсөн зохицуулалттай байна. Түүнчлэн сургуулиас

үзүүлэх дэмжлэгийн нэгээхэн хэсэгт нь ганцаарчилсан дэмжлэг мөн багтана.

- Үе тэнгийн дэмжлэгийн тогтолцоо нь хүүхдүүд бие биедээ туслахыг хөхиүлэн дэмжсэн, зохистой нөөц бололцоотой агаад бодит байдалд маш сайн дэмжлэг болдог байна.
- Хүүхдүүд сургуулийн багш, үйлчилгээний албаны ажилчдад итгэдэг, багш, ажилчид нь сурагчдыг ойлгон дэмждэг гэдгийг сургууль хүүхдүүдээсээ

мэддэг.

- Сургуулийн үйл ажиллагаанд сурагчдын оролцоог хангасан байна. Хэрвээ хүүхдүүд өөрсдийн үзэл бодол, байр суурь, санал хүсэлтээ илэрхийлбэл тэднийг анхааралтай сонсох төдийгүй шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэдгийг сурагчид мэддэг.

Сургуулийн зөвлөл гагцхүү дээрх механизм ажиллах тохиолдолд л өөрчлөлтийг хийж чадна.



УИИ.МН
СУДАЛГА АЛЫСАН

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЕХАНИЗМ ХАМГИЙН ҮР ДҮНТЭЙ.

Танай сургуулийн сурагчид үг хэлэх эрхтэй юу? Өөрсдийн дүгнэлтээ хариу мэдээлэх боломжтой юу?

Сурагчдын үзэл бодол байр суурь маш чухал болохыг олон судалгаа онцолдог.

- “Тойрог уулзалтын цаг” нь хамгийн түгээмэл сонсголын тогтолцоо бөгөөд сурагчид уулзалтыг өөрсдөө хөтлөх, агуулгыг чиглүүлэх боломж олгодог.
- “Санал асуулгын хуудас” нь сурагчдад тулгарч буй хүүхэд хамгаалал, тэр дундаа дээрэлхэлтийн асуудлыг илрүүлж, улмаар анхааралдаа авах, үр дүнтэй шийдвэрлэх боломж олгодог.

Сайн туршлагын гол санаанууд

- ° “Хэрвээ чи санаа зовнисон байвал багш чамтай ганцаарчлан уулзаж, чиний асуудалд маш анхааралтай хандана”
- ° “Санаа зовинолын хайрцаг бол “хэрвээ чи айдастай байгаа бол “санаа зовинолын хайрцаг”-ыг ашиглаж болно” гэсэн үг.
(Фокус бүлгийн ярилцалгын үеэр хүүхдийн хэлсэн үг)

Хүүхдүүд хэн нэгэнд асуудлаа ярих, чухам хэнд хэлэх вэ гэдгээ сонгох боломжтой, мөн тохирсон хариу арга хэмжээ авах болно гэдгийг мэддэг, итгэдэг байх ёстой. Тухайлбал, тойрог уулзалтын үеэр санаа зовинолын хайрцагт ирсэн асуудлыг дэлгэн гаргаж агуулгын дагуу хэлэлцдэг учир хүүхэд итгэдэг.

Хүүхдүүдэд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх боломж олгохоос гадна хариу арга хэмжээ нь хэр үр дүнд хүрч буйг эргэж мэдээлж байх хэрэгтэй. Ингэснээр тухайлбал, санал асуулгаар олж мэдсэн үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох журмуудыг хэрэглэсэн байдал, ялангуяа зан үйлийн холбогдолтой заалтуудад сургууль ямар суурьтай байгааг хүүхэд мэдэх болно. Үүний үр дүнд хүүхдүүд эдгээр асуудлыг өөриймшүүлж авах болно.

Хүүхдүүд сонсох болон бусдыг дэмжих тогтолцоонд шууд оролцох боломжтой.

Үе тэнгийн дэмжлэг – Сургуульд “Асуудлаа хуваалцах найз”, “Солонгон цагдаа”, “Нөхөрлөлийн салаа”, “Үе тэнгийн зөвлөгч” зэрэг нэршлийн дор нэгдсэн хүүхдүүд үе тэнгийнхнээ сонсож, дэмждэг. Эдгээр хүүхэд хүүхдээ дэмжих бүлэгт сургуулиас сургалт ордог бөгөөд дэмжин ажиллах ажилтан томилдог.

Найзууд – Шинэ сурагч шилжин ирэхэд тэднийг дасан зохицоход нь туслах найзын тогтолцоо байдаг. Энэ тогтолцоо нь эмзэг бүлгийн сурагчдад мөн адил тусалдаг.

Найзуудын тойрог – Энэхүү бүлэг нь асуудалтай сурагчдыг дэмжихэд оршино. “Найзуудын тойрог” нь бүгдийг тэгш хамруулсан, тэгш оролцоог хангасан буюу сургууль дээрээ хөгжлийн бэрхшээлээсээ болоод, хувийн чанартай асуудлаасаа болоод эсхүл бусдад эрсдэлтэй зан үйл гаргаснаасаа болоод гадуурхагддаг хэн бүхнийг хамруулан оролцуулна.

Сургуулийн форум болон бусад албан хэлэлцүүлэг

Сургуулийн зөвлөл нь тоглоомын талбайг дахин загварчлах, тоглоом хэрэгсэл захиалах, хүүхдүүд рүү чиглэсэн дэмжлэгийн бүлгүүдийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах мөн ангиуд болон ахлах удирдлагын багтай харилцах замаар сургуулийн хөгжилд нөлөөлнө. Судалгаа авсан сургуулиудын зарим хүүхдүүд “Орон Нутгийн Хүүхэд Хамгааллын зөвлөл”-ийн ажилд гар, бие оролцдог, сургуулийн үйл ажиллагаанд өөрийн хувь нэмрийг оруулдаг гэсэн байна. Мөн судалгаагаар болон “Би аюулгүй зөвлөгөөнд байна” хэлэлцүүлгийн үеэр боловсролын салбарын мэргэжилтэнгүүд сурагчдын оролцоо өндөр ач холбогдолтой болохыг онцолж байсан юм.

Жишээ

Английн Лондон хотын нэгэн сургууль “Асуудлаа хуваалцах найзууд” хэмээх тогтолцоотой. Энэ тогтолцоог хэрхэн ажиллуулдаг, оролцогчдын үүрэг, ролийг хөгжүүлэх тодорхой хэд хэдэн үе шатууд байдаг болох нь ярилцлагын үеэр тодорхой болсон юм. Үүнд:

- **Элсэлт:** “Асуудал Хуваалцах Найз” болохын тулд хүүхдүүд өргөдлийн маягт бөглөж, яагаад энэ ажлыг хийхийг хүсч байгаагаа ярилцлагын шатанд тайлбарлаж байлаа. Ярилцлагын үеэр хэсэг бүлэг хүүхдүүд нэгдэж, “асуудал хуваалцах найз” болохыг хүсч байв. Учир нь тэд өмнөх жил асуудалтай байсан бөгөөд тэд шаардлагатай тусламжийг авсан учраас эргээд бусдад туслахыг хүссэн байна.
- **Сургалт:** Хүүхдүүд ярилцлага өгсний дараа хоёр өдрийн сургалтанд хамрагдсан. Өөрсдийн үүргээ бахархалтайгаар гүйцэтгэхдээ юу хийж болох, юуг хийж болохгүй зэрэг өөрсдийн хэмжээ хязгаарыг сайтар ойлгосноо илэрхийлж байв. Сургалт тэдэнд хэзээ асуудлыг багш ажилчдад дамжуулан хүргэх болон бусад чадваруудаа хэзээ хөгжүүлэх хэрэгтэйг зааж өгсөн.
- **Өдөр бүр хийх ажил:** “Асуудлаа хуваалцах найзууд” жижүүрийн хуваарийн дагуу тоглоомын талбайд ээлжлэн ажиллаж тоглоомын талбайг ажиглаж байсан. Хүүхдүүд уулзалтын цаг авч санаа зовж байгаа зүйлсийнхээ талаар “Солонгон өрөө”-нд ярьж “Асуудлаа хуваалцах найз” нь тэднийг сонсож шийдлээ олоход нь тусалж байлаа.
- **Хяналт:** Тэд мөн хяналтын системтэй байсан, нэг хүүхэд зургаагаас дээш удаа хандвал шууд хариуцсан багш руу автоматаар шилжүүлдэг байсан.
- **Тогтвортой дэмжлэг:** Багш, ажилчдаас нэг хүн нь энэхүү үүрэг хариуцлагыг үүрэх бөгөөд “асуудлаа хуваалцах найзууд”-ын аюулгүй байдал болон сайн сайхан байдлыг тогтмол хангаж ажиллах нь хамгийн чухал билээ.

Үе тэнгийнхний бие биеэ дэмжих санаачлагад дээр дурдсан бүх бүрэлдэхүүн ажил маш чухал. Үе тэнгийнхэндээ тусалж чадна гэсэн итгэлийг хүлээх нь хүүхдүүдийн хувьд маш том дэмжлэг хийгээд бусдыг сонсох боломж юм. Сургуулийн олж мэдсэнээр “Асуудлаа Хуваалцах Найз” огт байхгүй эсхүл тэднийг огт мэдэхгүй байхыг хирээр асуудал томорч хүрээгээ тэлж байжээ.

ҮНДСЭН ОЙЛГОЛТ, НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Боловсрол дахь сайн туршлага

Хүүхэд болон багш нарын онцлог хэрэгцээг харуулсан нотолгоонд суурилсан үр дүн, практик

Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэд

Хараа, сонсгол, хөдөлгөөн, хэл яриа, оюуны бэрхшээл, аутизмын хүрээний эмгэг, суралцахуйн бэрхшээл, анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг, сургууль завсардсан хүүхдүүд

Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал

Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гаргах, хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн цогц . Эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алслагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ (Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016)

Гэр бүл, нийгэм дэх хүүхэд хамгаалал

Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээнүүдийн цогц.


Жендэрт суурилсан хүчирхийлэл

Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодь, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Үе тэнгийн дарамт дээрэлхэлт

Жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд, нийгмийн гарал үүсэл, статусаас хамааран ялгаварлах, гадуурхах, шоглох, заналхийлэх, цохих, тохуурхах, эд зүйлийг нь хулгайлах, дээрэмдэх шууд үйлдэл болох нэгнийхээ талаар бусдад мэдэгдэхийг хүсдэггүй хүсдэггүй нууц болон худал, үндэслэлгүй цуу яриа тарааж тухайн сурагчийг нийгмээс тусгаарлахад нөлөөлөх шууд бус үйлдлүүд орно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүн (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016)
Тэгш хамруулан сургах боловсрол	Суралцагсдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, хэл соёл, нийгмийн гарал, эдийн засгийн хүчин зүйлсээс үл хамааран хүн бүрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх, боловсрол эзэмших тэгш боломж болон эрхийг хангахад чиглэсэн үйл явц юм (Юнеско-ийн Монголын Үндэсний комисс, 2014). Тэгш хамруулан сургах боловсрол нь суралцагч бүрийг эрх эдлэгч гэж үздэг, тэднийг сургуулийн нэгэн булангаас анхаарлын төвд авчирдаг. Энэ нь хувь хүний бэрхшээлээс илүү нийгмийн нөхцөл байдалд анхаарлыг шилжүүлж байгаа хэрэг юм. Тэгш хамруулан сургах тогтолцоо нь хүүхэд боловсролын тогтолцоонд зохицохоос илүү боловсролын тогтолцоо хүүхдэд зохицохыг баталгаажуулахын тулд боловсрол, орон нутгийн, бүлгийн өөрчлөлтийг дэмждэг. Тэгш хамруулан сургах тогтолцоо нь хувь сурагчдын ялгаатай хэрэгцээнд тохируулах, тэр боломжид саад болж байгаа саад тотгорыг арилгахын тулд сургууль дахь соёл, содлого, практик үйл ажиллагааг өөрчлөн зохион байгуулах шаардлагыг хүлээн зөвшөөрдөг.
Тусгай хэрэгцээт боловсрол	Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн хувийн ялгаатай байдал, тусгай хэрэгцээнд нь нийцүүлэн боловсрол эзэмшүүлэх үйл явц.
Үндэстний цөөнх	Тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзэл бүхий тодорхой бүлэг хүмүүс юм.
Хүүхэд хамгаалал	Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ (Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016). Хүүхдийн аюулгүй байдлыг хэрхэн хангах тухай асуудал юм (ХИС, 2015).
Хүүхдэд ээлтэй, аюулгүй сургууль	Хүүхэд, суралцах үйл явцад ээлтэй эрүүл, аюулгүй, хамгаалагдсан орчныг (материаллаг, сэтгэл зүй, засаглалын) бүрдүүлсэн, хүний эрх, хүүхдийн эрхэд ээлтэй сургууль. Жишээ нь: ялгаварлан гадуурхал, хүчирхийлэл, дарамт дээрэлхэлтийн эсрэг урьдчилан сэргийлэх бодлого, бүтэцтэй байх гэх мэт



Хэлний цөөнх

Хүн ам (тоогоор цөөн), эдийн засаг (хөрөнгө чинээ багатай), улс төрийн хүчин зүйлээс хамааран эрх мэдэл харьцангуй багатай, нэг хэлээр ярьдаг бүлэг. Өөрөөр хэлбэл, нийгэмд цөөнх байдлаар амьдарч, дийлэнх олонхоос өөр хэлээр ярьдаг бүлэг юм.

Бэлгийн цөөнх

ЛГБТИК гэдэг нь бэлгийн цөөнхийг хэлэх олон улсын хэвшмэл нэр томъёоны товчлол юм. “Л” гэдэг нь ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай эмэгтэйчүүд буюу лесбиян, “Г” нь ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай эрэгтэйчүүд буюу гей, “Б” нь аль аль хүйсийн хүмүүст чиглэсэн бэлгийн чиг баримжаатай бисексуал хүмүүс бол “Т” нь өөрийн хүйсийг төрсөн хүйсээсээ өөрөөр эсвэл эсрэгээр мэдэрч, мэдэрч буйгаараа хүйсээ илэрхийлж амьдардаг транс хүмүүсийг хэлдэг. “И” нь аль аль хүйсийн анхдагч болон хоёрдогч бэлгийн шинж чанарыг буюу хромосом, гонад болон нөхөн үржихүйн эрхтэний хувьд эр, эм аль хүйст хамаарахыг нь шууд хэлэх боломжгүй хүмүүсийг интерсекс гэнэ. “К” нь бэлгийн чиг баримжаа болоод хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд цөөнх хүмүүсийг нийтэд нь ЛГБТИ эсвэл Күйр гэдэг. Түүхийн хувьд энэхүү үг нь нэлээд сөрөг утга агуулдаг байсан ч энэ үгийг ЛГБТИ хүмүүс өөрийн болгож авч чадсан. Хэдийн тийм ч бүх ЛГБТИ хүмүүс энэ үгийг өөртөө хамаатуулан ашигладаггүй. Ихэвчлэн энэ нэр томъёог хүйс болон бэлгийн чиг баримжааг хоёрхон туйлт хэмээн үзэхийн эсрэг байдаг ЛГБТИ хүмүүс хэрэглэдэг.

Бэлгийн чиг баримжаа гэж юу вэ?

Бэлгийн чиг баримжаа гэдэг нь, хүн бүрийн хэн нэгэнд сэтгэл, бие махбодь, хайр дурлалын хувьд татагдах төрөлхийн өөрчлөгдөшгүй мөн чанар, мэдрэмж юм. Бэлгийн чиг баримжааг ерөнхийд нь 3 ангилдаг. Үүнд: 1) Эсрэг хүйсийнхээ хүнд татагддаг бол стрэйт 2) Ижил хүйсийнхээ хүнд татагддаг бол гей, лесбиян, 3) Аль аль хүйсийн хүнд татагддаг бол бисексуал гэдэг.

Маргиналчлагдсан бүлэг.

Нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэйгээр урт хугацаанд нийгэм эдийн засгийн статусын хувьд гадуурхагдаж, боловсролын бодлого төлөвлөлтийн хийдлийн улмаас сурч боловсрох эрх нь зөрчигдсөн бүлэг. Энэхүү судалгаанд нийгэм эдийн засгийн статусын хувьд доогуур орлоготой өрхөд амьдарч буй, үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй болон жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч гэсэн дөрвөн бүлгийн хүүхдийг авч үзсэн болно.

Нийгэм, эдийн засгийн статусын хувьд доогуур орлоготой өрхийн хүүхдүүд

Алслагдсан сум дүүрэг, хороодын нийгэм-эдийн засгийн статусын хувьд эмзэг байдалд байгаа амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдарч буй хүүхдүүд. Энэхүү судалгаанд дээрх агуулгыг эмзэг бүлгийн, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхэд зэрэг нэршлээр оруулсан болно. Учир нь судалгаанд хамрагдсан байршил бүр өөр өөрийн нэршлээр мэдээлэл өгч байсан бөгөөд нэгдсэн нэг ойлголт, тодорхойлолт байхгүй нь судалгааны явцад харагдсан.

Хавсралт

Тодорхой бүлгийн хүүхдүүдийг эрх тэгш, тэгш хамруулан суралцуулж буй жишиг болохуйц сургуулиудын сайн туршлага

I. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

УДИРТГАЛ

Боловсролд тэгш хамруулах явдал нь улс төр, нийгмийн өөрчлөн байгуулалтын үр дүнд хүмүүсийн эрхэмлэх зүйлс төлөвшихөд хувь нэмрээ үзүүлдэг гэдгийг тэгш хамруулах боловсролын тогтолцоо хөгжсөн олон улсын туршлага харуулж байна. ТХСБ нь суралцагчдын нийгэм, эдийн засаг, соёл, хэл, хүйс, бие махбод бусад зүйлээс үл хамааран бүх суралцагчдын харилцан адилгүй хэрэгцээнд анхаарлаа хандуулан, түүнийг хангаснаар боловсролын тогтолцоонд хийгдэх өөрчлөлтийн цогц үйл явц юм. Тэгш хамруулах боловсролын үйл явц нь:

- Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх
- Боловсролын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх
- Боловсролын үйлчилгээний хүрээ, арга замыг сайжруулах
- Сурах орчинг сайжруулах, эрх тэгш байдлыг хангах
- Хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үзэл хандлага, сургалтын орчин, багшийн сургалтын аргазүй, харилцааг өөрчлөхөд чиглэгддэг.

Монгол улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулан сургах үзэл санаа туссан хэдий ч хэрэгжилтийг хангах зохицуулалт, журам хангалтгүй, хэрэгжүүлэх

арга зам тодорхойгүй байна (ХИС, Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь, 2018). Боловсролын тусгай хэрэгцээт хүүхдэд ихэвчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг (ХБХ) хамруулан ойлгож байгаа нь учир дутагдалтай бөгөөд үүнд ч онцлог хэрэгцээтэй хүүхдүүдийн асуудал хэлэлцэгдэх ёстой. Иймд Бүх нийт боловсролын төлөө! иргэний нийгмийн үндэсний эвсэл нь 2020-2021 онд боловсролоос маргиналчлагдсан, эмзэг бүлгүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тэдэнд тулгарч буй саад тотгор, тэдний эрэлт хэрэгцээний талаар бодлого боловсруулагчид, олон нийтийн ойлголт мэдлэгийг гүнзгийрүүлэх, баримт нотолгоо бүрдүүлж, холбогдох хууль, бодлого болон хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөх зорилготой ажиллаж байна. Боловсролын эвсэлийн салбар зөвлөл нь Улаанбаатар хотын 4 дүүрэг, 12 аймагт ажилладаг.

Энэхүү ажлын хүрээнд Боловсролын эвсэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх орон нутаг, Улаанбаатар хотын сургуулиудын сайн туршлагыг цуглуулах хэрэгцээ шаардлага байна.

ОИН.МН
СУДАЛГААНЫ САН

Зорилго

Нийгмийн маргиналчлагдсан¹ бүлгийн хүүхдүүдийг боловсролд эрх тэгш, тэгш хамруулан сургаж буй сургуулийн сайн туршлагыг судалж, үр дүнд нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглахуйц нотолгоо, жишиг туршлагыг судалгааны талбараар гаргана.

Энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан болно. Үүнд:

- Зорилтот талбаруудын сайн туршлагыг үнэлэх
- Зорилтот 4 бүлгийн хүүхдүүдийг эрх тэгш, тэгш хамруулан суралцуулж буй сургуулиудын жишиг туршлагын агуулга, үр дүн, үр нөлөө, хэрэгжих боломж, тогтвортой байдал, сургамжийг судлах
- Жишиг болохуйц сайн туршлагын талаар санал зөвлөмжийг боловсруулна.

Зорилтот бүлгүүд

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд
- Үндэстний цөөнх
- Алслагдсан сум дүүрэг, хороодын нийгэм-эдийн засгийн статусын хувьд эмзэг байдалд байгаа амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдарч буй хүүхдүүд²
- Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч³

1 Нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэйгээр урт хугацаанд гадуурхагдаж, боловсролын бодлого, төсөвлөлтийн хийдлээс сурч боловсрох эрх нь зөрчигдсөн бүлэг

2 Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль. 5-р зүйл. УИХ.1998. Хэрэглээний доод хэмжээг тогтоосон түвшин Улаанбаатар-230.0, Хангайн бүс-206.0, Баруун бүс-203.4, Зүүн бүс-201.7, Төвийн бүс-198.3 мянган төгрөгөөр 2020 онд ҮСХ-ноос шинэчлэн тогтоосон.

3 ЖСХ-ийн хохирогч гэдэгт хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, үе тэнгийн дарамт дээрэлхэлтийн хохирогч болсон хүүхдүүдийг ойлгох.

Дүн шинжилгээний хамрах хүрээ

- Улаанбаатар хот: Налайх, Багануур, СХД, БЗД-ийн ЕБС-иуд
- Орон нутаг: Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Өвөрхангай, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Булган, Өмнөговь, Дорнод болон Сүхбаатар аймгуудын ЕБС-иуд

Судалгааны аргачлал: Практикт суурилсан судалгааны арга зүйд суурилав. Тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан хэрэглэнэ.

Судалгааны хэрэглэгдэхүүн, түүвэр

Хүснэгт 1-д харуулсан шинжилгээний агуулгын хүрээнд мэдээлэл цуглуулах зорилгоор зорилтот талбаруудын сайн туршлагын оролцогч талуудыг судалгаанд хамруулав.

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа

Нөхцөл байдлаас шалтгаалан судалгааны мэдээллийг цахимаар болон биечлэн цуглуулна.

Судалгааны мэдээлэл цуглуулалт дараах 2 үе шатаар зохион байгуулагдана. Үүнд:

Нэгдүгээр шат: Талбаруудын жишиг болохуйц сайн туршлагыг цуглуулна.

Хоёрдугаар шат: Жишиг болохуйц сайн туршлагыг баталгаажуулах зорилготой эцэг эхийг оролцуулсан фокус бүлгийн хэлэлцүүлгийг зохион байгуулна.

Судалгааны шинжилгээ

Жишиг болохуйц сайн туршлагыг судлахдаа чанарын мэдээллийг түлхүү ашиглана. Чанарын мэдээллийг боловсруулахад агуулгын шинжилгээ, логик шинжилгээ, хэв маягчлал, ангилал хийх зэрэг аргуудыг хэрэглэнэ.

Судалгааны бэрхшээлтэй талууд

COVID-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан мэдээлэл цуглуулалтын хугацаа хойшлогдох талтай.

Хүснэгт 1. Судалгааны хэрэглэгдэхүүн, шинжилгээний хүрээ

Судалгаанд оролцогч	Арга	Шинжилгээний хүрээ
Сургуулийн удирдлага	Баримт бичгийн шинжилгээ	Сургуулийн талаар ерөнхий мэдээлэл, зорилтот болон эмзэг бүлгийн суралцагчдын мэдээлэл, эрх тэгш, тэгш хамруулан сургах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа, сургууль болон аймаг/дүүргийн түвшинд гаргасан тушаал, шийдвэр, зөвлөмж, тайлан.
Сургуулийн багш нар	Хагас бүтэцлэгдсэн ярилцлага	Зорилтот бүлгийн хүүхдүүдийг эрх тэгш, тэгш хамруулан суралцуулж буй сургуулиудын жишиг туршлагын агуулга, үр дүн, үр нөлөө, хэрэгжих боломж, тогтвортой байдал, сургамж

Түүврийн төлөвлөлт

Хүснэгт 1. Түүвэр, зорилтот бүлгээр

№	Аймаг/дүүргийн нэр	ХБ-тэй хүүхэд	Үндэстний цөөнх	Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдарч буй хүүхдүүд	Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч
Улаанбаатар хот					
1	Багануур	1		1	1
2	Налайх	1	1	1	
3	БЗД	1		1	1
4	ХУД	1		1	
Орон нутаг					
1	Баян-Өлгий	1	1	1	
2	Ховд	1	1	1	1
3	Увс	1		1	
4	Завхан	1		1	
5	Өвөрхангай	1		1	1
6	Архайнгай	1		1	
7	Хөвсгөл	1		1	
8	Архангай	1		1	1
9	Булган	1		1	
10	Өмнөговь	1		1	1
11	Дорнод	1		1	1
12	Сүхбаатар	1		1	
Нийт		16	3	16	7

Тайлбар: Түүврийн төлөвлөлт нь зорилтот бүлгийн хүүхдийн туршлага судалгааны талбарт байгаа эсвэл байхгүйгээс шалтгаалан өөрчлөгдөж болно.

II. СУДЛААЧДЫН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГАЧЛАЛ

Мэдээлэл цуглуулагчид дараах шалгуур үзүүлэлтийн дагуу сайн туршлагыг сонгоно.

1. Шилдэг туршлагын шалгуур үзүүлэлт

- Шалгуур 1. Туршлага хэрэгжүүлсэн хугацаа нь 6 сараас доошгүй байна.
- Шалгуур 2. Багш хүүхэд, эцэг эхтэй долоо хоногт 2-3 удаа уулзаж, хамтарч ажилласан байна.
- Шалгуур 3. Багш хүүхдийн хөгжлийг тогтмол үнэлдэг байна.
- Шалгуур 4. Оролцогч талууд болох багш, эцэг эх, хүүхэд туршлагыг үр дүтнэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна.
- Шалгуур 5. Тэгш хамруулан сургаж буй туршлагыг сургууль болон орон нутгийн түвшинд хэлэлцүүлсэн байна.

Маргиналчлагдсан бүлгийн хүүхдүүдэд учирч болох саад тотгорын жишээ. Эдгээрийг бууруулах, үгүй болгохын төлөө авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, бодлого, арга хэмжээ нь тухайн хүүхэд, гэр бүл эцэг эх болон багш сургуульд эерэг өөрчлөлт авчирсан бол сайн туршлага болно.

№	Бүлгүүд	Сургуульд сурахад учирч буй саад тотгор
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	<ul style="list-style-type: none"> - Тээвэр, унаа - Ялгаварлан гадуурхалт (хэл амаар доромжлох, шоолох, үйл ажиллагаанд оролцуулахгүй байх) - Мөнгө, санхүү - Зам талбай, налуу шат, бариул - Биеийн жин - Тусгай хэрэгсэл (бэрхшээлд тохирсон ширээ, сандал) - Шударга бус байдал (үнэлгээ, харилцаа) - Хичээлийн цаг (эрт эсвэл орой тарах) - Жендэрт суурилсан хүчирхийлэл (гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг)
2	Үндэсний цөөнх	<ul style="list-style-type: none"> - Хэлний бэрхшээл - Ялгаварлан гадуурхалт - Соёл, шашны ялгаа - Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл (бие махбодь, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн)
3	Амжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдарч буй хүүхэд	<ul style="list-style-type: none"> - Мөнгө санхүү - Тээвэр, унаа - Хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцас - Ялгаварлан гадуурхалт - Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл (бие махбодь, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн), хөдөлмөрийн мөлжлөг, гуйланчлах, үл хайхрах
4	Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд	<ul style="list-style-type: none"> - Ялгаварлан гадуурхалт - Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл (бие махбодь, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн дарамт, шахалт, мөлжлөг), хөдөлмөрийн мөлжлөг, гуйланчлах, үл хайхрах - Санхүү, мөнгө - Унаа тээвэр - Сэтгэл зүйн хямрал, цочрол, айдас

2.Мэдээлэл цуглуулагчид дараах ёс зүйн шаардлагуудыг баримтална.

Ёс зүйн шаардлагууд

1. Судлаач өөрийн аюулгүй байдлаа, COVID-19 цар тахлаас өөрийгөө сайтар хамгаална (мэдээлэл цуглуулах ажил 10-15 цагийн хооронд зохион байгуулах, маск зүүх, гар ариутгал байнга биедээ авч явах, мэдээлэл авахаас өмнө судалгаанд оролцогчтой утсаар ярин биеийн нөхцөл байдлыг тандан мэдэх).
2. Судалгаанд оролцогчийн нас, хүйс, шашин шүтлэг, эрхэлж буй ажил, бэлгийн чиг баримжаа, улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.
3. Судалгаанд оролцогчийн хувийн нууцыг хүндэтгэн үзнэ.
4. Судалгаа нь ХБХ-д чиглэсэн сургалтын асуудлаар хийгдэх тул “Хөгжлийн Бэрхшээл”-ийн талаар урьдчилан сайтар ойлголтоотой байх бөгөөд тэдгээр хүүхдийн эрхэм чанар, эрхийг хүндэтгэх учиртай.

3.Мэдээлэл цуглуулагчид мэдээллийн чанарыг хариуцаж ажиллана.

1. Мэдээлэл цуглуулагч нь судалгааны бүхий л үйл явцад судалгааны удирдамж, төлөвлөгөөний дагуу ажиллана.
2. Мэдээлэл цуглуулагч нь судалгааны бүхий л үйл явцад зөвлөхийн зүгээс тавьсан шаардлагыг хангаж ажиллана.
3. Мэдээлэл цуглуулагч судалгааны түүврийн бүтэц, хэмжээ, төлөөллийг мэргэжлийн түвшинд баримтлан ажиллана.
4. Мэдээлэл цуглуулагч нь судалгааны бүхий л үйл явцад мэдээллийн чанарт анхаарал тавьж, түүнийг дээшлүүлэх талаар санаачлагатай ажиллана.
5. Мэдээлэл цуглуулагч мэдээлэл авсны дараа судалгаанд оролцогчид талархал илэрхийлнэ.

4.Судалгааны мэдээллийг туршлагыг хэрэгжүүлсэн сургуулийн удирдах албан тушаалтан болон багш нараас авна.

Судалгааны хэрэглэгдэхүүнийг ашиглах байдал

1. Баримт бичгийн судалгааг туршлага хэрэгжүүлсэн сургуулийн нэг удирдах албан тушаалтнаас (захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан) авна.
2. Хагас бүтэцлэгдсэн ярилцлагыг туршлага хэрэгжүүлсэн багшаас авна.

Судалгааны хэрэглэгдэхүүн 1.

“ТОДОРХОЙ БҮЛГИЙН ХҮҮХДҮҮДИЙГ ЭРХ ТЭГШ, ТЭГШ ХАМРУУЛАН СУРАЛЦУУЛЖ БҮЙ ЖИШИГ БОЛОХУЙЦ СУРГУУЛИУДЫН САЙН ТУРШЛАГА”-ын баримт бичгийн шинжилгээ

(Сургуулийн удирдах ажилтнуудад зориулав)

Бүх нийтийн боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвсэл нь 2020-2021 онд боловсролоос маргиналчлагдсан, эмзэг бүлгүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тэдэнд тулгарч буй саад тотгор, тэдний эрэлт хэрэгцээний талаар бодлого боловсруулагчид, олон нийтийн ойлголт мэдлэгийг гүнзгийрүүлэх, баримт нотолгоо бүрдүүлж, холбогдох хууль, бодлого болон хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөх зорилготой ажиллаж байна. Энэхүү судалгаа нь боловсролд завсрын, эмзэг бүлгийн хүүхдүүдийг боловсролд эрх тэгш байдлаар тэгш хамруулан сургаж буй сургуулийн сайн туршлагыг цуглуулах зорилготой юм. Таны мэдээллийн нууцлалыг бид чандлан хадгалж, зөвхөн судалгаанд ашиглах болно.

Сургуулийн нэр, байршил:
Огноо:
Удирдах ажилтны овог, нэр, албан тушаал:
Дүн шинжилгээ хийсэн судлаач:

Хүснэгт 1. Сургуулийн ерөнхий мэдээлэл

№	Үндсэн мэдээлэл	Хүйс		Тайлбар, нотолгоо баримт бичгийг хавсаргах
		Эрэгтэй	Эмэгтэй	
	Суралцагчдын тоо			
	Багшийн тоо			
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо			
	Үндэстний цөөнх хүүхдийн тоо			
	Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч			
	Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхөд амьдарч байгаа хүүхэд			
	Эрх тэгш, тэгш хамран сургах чиглэлээр сургалтанд хамрагдсан багшийн тоо			

Хүснэгт 2. Эрх тэгш, тэгш хамран сургах чиглээр зохион байгуулсан үйл ажиллагаа, туршлага

№	Үндсэн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны агуулга	Нотолгоо баримт бичгийг хавсаргах
	Тэгш хамран сургах чиглэлээр сургуулийн зүгээс зохион байгуулсан үйл ажиллагаа		
	Тэгш хамруулан сургах чиглэлээр төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагуудын зүгээс зохион байгуулсан үйл ажиллагаа		
	Багш нарт үзүүлж буй зөвлөгөө, мэргэжил арга зүйн дэмжлэг авсан байдал		
	Эрх тэгш, тэгш хамруулан сургах чиглэлээр орон нутгийн түвшинд гаргасан тушаал, шийдвэр, зөвлөмжийн тоо		
	Эрх тэгш, тэгш хамруулан сургах чиглэлээр сургуулийн түвшинд гаргасан тушаал, шийдвэр, зөвлөмж	Адил боломж, хбх	
	Тэгш хамруулан сургах чиглэлээр хэрэгжүүлж буй сайн туршлага		
	Тэгш хамруулан сургах сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх сонирхол		
	Үйл ажиллагааны тайлан (Эрх, тэгш хамруулан сургахтай холбоотой ажлууд)		



Судалгааны хэрэглэгдэхүүн 2.

Хагас бүтэцчилэгдсэн стандарт ярилцлага

(Багш нарт зориулав)

Бүх нийтийн боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвсэл нь 2020-2021 онд боловсролоос маргиналчлагдсан, эмзэг бүлгүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тэдэнд тулгарч буй саад тотгор, тэдний эрэлт хэрэгцээний талаар бодлого боловсруулагчид, олон нийтийн ойлголт мэдлэгийг гүнзгийрүүлэх, баримт нотолгоо бүрдүүлж, холбогдох хууль, бодлого болон хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөх зорилготой ажиллаж байна. Энэхүү судалгаа нь боловсролд завсрын, эмзэг бүлгийн хүүхдүүдийг боловсролд эрх тэгш байдлаар тэгш хамруулан сургаж буй сургуулийн сайн туршлагыг цуглуулах зорилготой юм. Таны мэдээллийн нууцлалыг бид чандлан хадгалж, зөвхөн судалгаанд ашиглах болно.

Судлаачийн бөглөх хэсэг

	Бичих	Код	Судалгаа авсан			
Аймаг\нийслэлийн нэр			Он			
Сум\дүүргийн нэр			Сар			
Сургуулийн нэр			Өдөр			

	Код
Судалгаанд оролцсон багшийн овог, нэр	В. Норжин
Багшийн даасан анги	12
Мэдээлэл цуглуулагч	

А. Тэгш эрх, тэгш хамран сургах чиглэлээрх багшийн сайн туршлагын мэдээлэл

Тэгш хамруулан сургах туршлагын агуулга

1. Таны бодлоор тэгш хамруулан сургах боловсролыг хэрхэн ойлгож байна вэ?
2. Сургуулийн бодлогод тэгш хамруулан сургах талаар туссан уу? (Хэрвээ туссан бол ямар баримт бичгүүдэд туссаныг дэлгэрэнгүй асууна уу)
3. Танай сургууль дээр тэгш хамруулан сургах чиглэлээр ямар үйл ажиллагаа хэрэгжиж байна вэ?
4. Доор заасан бүлгийн хүүхдүүдийн онцлог, тусгай хэрэгцээг хангасан ямар нөхцөлийг сургууль болон ангидаа бүрдүүлсэн бэ?
 - a. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд
 - b. Үндэстний цөөнх
 - c. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч
 - d. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдарч буй хүүхэд
5. Аль бүлгийн хүүхэдтэй тэгш хамруулан сургах туршлагыг хэрэгжүүлж байна вэ?
6. Энэхүү туршлагыг хэнтэй хамтран зохион байгуулсан бэ? (Жишээ нь: сургууль, багш, эцэг эх, төрийн бус байгууллага гэх мэт)
7. Хэний санаачлагаар тэгш хамруулан сургах туршлагыг хэрэгжүүлсэн бэ?
8. Туршлагын хүрээнд ямар үйл ажиллагаануудыг зохион байгуулсан бэ?
9. Туршлагыг хэдийн хэр хугацаанд хэрэгжүүлсэн бэ? (эхэлсэн, дууссан хугацаа)

Сайн туршлагын үр дүн, үр өгөөж

1. Энэхүү туршлагыг багш хэрэгжүүлснээр ямар өөрчлөлтийг бий болгож байна вэ? Ямар мэдлэг, ур чадвар, туршлага хуримтлуулсанаа хуваалцана уу.
2. Багш хүүхдийн хөгжлийг үнэлэх ямар аргачлалыг ашигласан бэ?
3. Туршлагыг эцэг эхчүүд хэрхэн үнэлж байна вэ? Зорилтот бүлгийн хүүхдийг тэгш хамруулан сургахдаа гэр бүлийн гишүүд, ялангуяа эцэг эхийн оролцоог хэрхэн хангасан бэ?
4. Хүүхэд хэр сэтгэл хангалуун байна вэ?
5. Таны хэрэгжүүлсэн үйл ажиллагааны туршлагаар багш, хүүхэд, эцэг эх, бусад оролцогч талууд хамтран ажиллах нь илүү үр дүнтэй болохыг баталж чадсан уу?

Хэрэгжих боломж, тогтвортой байдал

1. Таны бодлоор энэхүү туршлагыг бусад сургууль, багш нар авч хэрэгжүүлэх хэр боломжтой вэ? Сургууль болон багш нарт ямар нөөц боломж байна вэ?
2. Энэхүү туршлага нь бусад багш нарын уг туршлагыг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл, сэдэлд нөлөөлж чадсан уу?
3. Энэхүү туршлагыг цаашид урт хугацаанд тогтвортой байлгахад ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай вэ?

Б. Тэгш эрх, тэгш хамран сургаж буй сайн туршлагын нэгтгэл хүснэгтийг бөглөнө үү.

Сайн туршлагын нэр	Хэмжих үзүүлэлтүүд	Тайлбар, баталгаажуулалт
Санаачлагч, хэрэгжүүлэгч	<ul style="list-style-type: none"> • АУБ, багш, сургуулийн удирдлага, • Эцэг эх • Төрийн байгууллага • Төрийн бус байгууллага /ТББ/, • Олон улсын байгууллага /ОУБ/ 	

Сайн туршлагын агуулга	<ul style="list-style-type: none"> • Сурлагын амжилтыг ахиулах • Эцэг эхийг оролцоотой болгох • Төсөв шийдэх • Хүүхдийг нийгэмшүүлэх • Ангийн сурагчдын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх • Бусад 	Тоглоомын арга
Сайн туршлагын үр дүн, үр нөлөө	<ul style="list-style-type: none"> • Сурлагын чанар нэмэгдсэн. • Эцэг эх оролцоотой болсон. • Орчныг бүрдүүлэх төсөв шийдсэн. • Орчныг бүрдүүлсэн. • Сургууль, эцэг эх, байгууллагуудын холбоо сайжирсан. • Бусад 	Эцэг эх багш хамтарч ажилладаг болсон Эцэг эхчүүд мэдлэгийн богцдоо баяжуулалт хийсэн Бүтээлч эцэг эх бүтээлүүд
Хэрэгжих боломж	<ul style="list-style-type: none"> • Хууль, дүрэм журам баталсан. • Хууль, дүрэм журам, хөтөлбөрт тусгасан. • Эцэг эхийн идэвх оролцоо, санаачилга сайн. • Багшийн мэдлэг, ур чадвар сайжирсан. • Багшийн ажлын байрны тодорхойлолтод тусгаж өгсөн. • Сурагчдын ойлголт, мэдлэг сайжирсан. • Сургуулийн уд • Бусад 	Туршиж үзвэл ямрав гэдэг талаасаа Туршлага хуваалцах замаар
Тогтвортой байдал	<ul style="list-style-type: none"> • Төлөвлөгөөнд тусган оруулна. • Хамтын ажиллагаа сайжирна. • Багшийн урамшууллын системийг оновчтой болгоно. • Сургуулийн орчин сайжирна. • Сургуулийн удирдлага, багш, эцэг эхэд туршлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх сэдэл, сонирхол байна. 	
Сургамж	<ul style="list-style-type: none"> • Туршлагыг илүү үр дүнтэй байлгах саналууд 	

“ТОДОРХОЙ БҮЛГИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЫН ЖИШИГ БОЛОХУЙЦ ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ, АЮУЛГҮЙ СУРГУУЛИУДЫН САЙН ТУРШЛАГА ЦУГЛУУЛАХ СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Судалгааны хэрэглэгдэхүүн 1

1.БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭ

(Сургуулийн удирдах ажилтнуудад зориулав)

Бүх нийтийн боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвсэл нь 2020-2021 онд боловсролоос маргиналчлагдсан, эмзэг бүлгүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тэдэнд тулгарч буй саад тотгор, тэдний эрэлт хэрэгцээний талаар бодлого боловсруулагчид, олон нийтийн ойлголт мэдлэгийг гүнзгийрүүлэх, баримт нотолгоо бүрдүүлж, холбогдох хууль, бодлого болон хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөх зорилготой ажиллаж байна. Энэхүү судалгаа нь боловсролд завсрын, эмзэг бүлгийн хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй сургуулийн сайн туршлагыг цуглуулах зорилготой юм. Таны мэдээллийн нууцлалыг бид чандлан хадгалж, зөвхөн судалгаанд ашиглах болно.

Сургуулийн нэр, байршил:
Огноо:
Удирдах ажилтны овог, нэр, албан тушаал:
Дүн шинжилгээ хийсэн судлаач:

Хүснэгт 1. Сургуулийн ерөнхий мэдээлэл

№	Үндсэн мэдээлэл	Хүйс		Тайлбар, нотолгоо баримт бичгийг хавсаргах
		Эрэгтэй	Эмэгтэй	
	Суралцагчдын тоо			
	Багшийн тоо			
	Үндэстний цөөнх хүүхдийн тоо			
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд			
	Жендэрт суурилсан хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн хохирогч болсон хүүхдийн тоо			

Алслагдсан сум дүүрэг, хороодын нийгэм-эдийн засгийн статусын хувьд эмзэг байдалд байгаа амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур ¹ орлоготой өрхөд амьдарч буй хүүхдүүд			
Хүүхэд хамгааллын чиглэлээр сургалтанд хамрагдсан багшийн тоо			

Хүснэгт 2. Хүүхэд хамгааллын чиглээр зохион байгуулсан үйл ажиллагаа, туршлага

№	Үндсэн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны агуулга	Нотолгоо баримт бичгийг хавсаргах
	Хүүхэд хамгааллын чиглэлээр сургуулийн зүгээс зохион байгуулсан үйл ажиллагаа		
	Хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагуудын зүгээс зохион байгуулсан үйл ажиллагаа		
	Багш нарт үзүүлж буй зөвлөгөө, мэргэжил арга зүйн дэмжлэг авсан байдал		
	Хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутгийн түвшинд гаргасан тушаал, шийдвэр, зөвлөмжийн тоо		

1 Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль. 5-р зүйл. УИХ.1998. Хэрэглээний доод хэмжээг тогтоосон түвшин Улаанбаатар-230.0, Хангайн бүс-206.0, Баруун бүс-203.4, Зүүн бүс-201.7, Төвийн бүс-198.3 мянган төгрөгөөр 2020 онд ҮСХ-ноос шинэчлэн тогтоосон.

Хүүхэд хамгааллын чиглэлээр сургуулийн түвшинд гаргасан тушаал, шийдвэр, зөвлөмж		
Хүүхэд хамгааллын чиглэлээр сургууль дээр хэрэгжүүлж буй сайн туршлага		
Хүүхэд хамгааллын чиглэлээр дотуур байранд хэрэгжүүлж буй сайн туршлага		
Хүүхэд хамгааллын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх сонирхол		
Үйл ажиллагааны тайлан (Хүүхэд хамгаалалтай холбоотой ажлууд)		

Судалгааны хэрэглэгдэхүүн 2.

ХАГАС БҮТЭЦИЛЭГДСЭН СТАНДАРТ ЯРИЛЦЛАГА

(Багш нарт зориулав)

Бүх нийтийн боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвсэл нь 2020-2021 онд боловсролоос маргиналчлагдсан, эмзэг бүлгүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тэдэнд тулгарч буй саад тотгор, тэдний эрэлт хэрэгцээний талаар бодлого боловсруулагчид, олон нийтийн ойлголт мэдлэгийг гүнзгийрүүлэх, баримт нотолгоо бүрдүүлж, холбогдох хууль, бодлого болон хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөх зорилготой ажиллаж байна. Энэхүү судалгаа нь боловсролд завсрын, эмзэг бүлгийн хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй сургуулийн сайн туршлагыг цуглуулах зорилготой юм. Таны мэдээллийн нууцлалыг бид чандлан хадгалж, зөвхөн судалгаанд ашиглах болно.

Судлаачийн бөглөх хэсэг

	Бичих	Код		Судалгаа авсан			
Аймаг\нийслэлийн нэр				Он			
Сум\дүүргийн нэр	Булган аймаг			Сар			
Сургуулийн нэр	Эрдмийн өргөө			Өдөр			

	Код
Судалгаанд оролцсон багшийн овог, нэр	Ахайян
Багшийн даасан анги	1
Мэдээлэл цуглуулагч	

А. Хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй багшийн сайн туршлагын мэдээлэл

Хүүхэд хамгааллын туршлагын агуулга

- Таны бодлоор хүүхдэд ээлтэй сургууль, хүүхэд хамгаалал гэсэн ойлголтуудыг хэрхэн ойлгож байна вэ?
Материаллаг, гааад, сэтгэл зүйн орчин
- Сургуулийн бодлогын баримт бичгүүдэд хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бий болгох хүүхэд хамгааллын ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан бэ? (баримт бичгүүдийг дэлгэрэнгүй асууна уу)
Сургуулийн Б төлөвлөгөөнд, Нийгмийн ажилтан мэддэг, сэтгэлзүйн судалгаа
Эрсдэлт бүлгийн хүүхдүүдийг сонгоод, тэдэнд хандсан үйл ажиллагаа, ахуйн, хувцас, хичээл сурлага,
Энхтэмүүлэл 2 ангид бхдаа, Бямбасүрэн ээж
- Танай сургууль эсвэл дотуур байранд хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлсэн, хүүхэд хамгааллын чиглэлээр ямар үйл

ажиллагаа хэрэгжүүлж байна вэ?

- Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд сургууль эсвэл дотуур байранд хүүхдэд ээлтэй аюулгүй ямар нөхцөлийг бүрдүүлсэн бэ?
- Таны хэрэгжүүлж буй хүүхэд хамгааллын туршлагад хэн хамрагдсан бэ?
 - Үндэстний цөөнх
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
 - Жендэрт суурилсан хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн хохирогч хүүхдүүд
 - Алслагдсан сум, дүүрэг, хороодын нийгэм-эдийн засгийн статусын хувьд эмзэг байдалд байгаа өрхийн хүүхдүүд
- Энэхүү туршлагыг хэнтэй хамтран зохион байгуулсан бэ? (Жишээ нь: сургууль, багш, эцэг эх, төрийн бус байгууллага гэх мэт)
- Хэний санаачлагаар хүүхэд хамгааллын туршлагыг хэрэгжүүлсэн бэ?
- Туршлагын хүрээнд ямар үйл ажиллагаануудыг зохион байгуулсан бэ?
- Туршлагыг хэдийн хэр хугацаанд хэрэгжүүлсэн бэ? (эхэлсэн, дууссан хугацаа)

2018 оноос

Сайн туршлагын үр дүн, үр өгөөж

- Энэхүү туршлагыг багш хэрэгжүүлснээр хаана (анги танхим, сургууль, суралцагчийн гэр бүл, орон нутаг гэх мэт) ямар өөрчлөлтийг бий болгож байна вэ? Ямар ур чадвар, туршлага хуримтлуулсан талаар дэлгэрэнгүй асууна уу.
- Туршлагыг хэрэгжүүлснээр хүүхдэд ямар үр нөлөө үзүүлсэн бэ?
- Туршлагыг эцэг эхчүүд хэрхэн үнэлж байна вэ?
- Хүүхэд хэр сэтгэл хангалуун байна вэ?

Хэрэгжих боломж, тогтвортой байдал

1. Таны бодлоор энэхүү туршлагыг хэрэгжүүлэх хэр боломжтой вэ? Сургууль болон багш нарт ямар нөөц боломж байна вэ?
2. Туршлагыг амжилттай хэрэгжүүлэхэд танай сургуулийн зүгээс ямар дэмжлэгийг үзүүлсэн бэ?
3. Энэхүү туршлага нь бусад багш нарын уг туршлагыг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл, сэдэлд нөлөөлж чадсан уу?
4. Энэхүү туршлагыг цаашид тогтвортой байлгахад ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай вэ?

Б. Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй сайн туршлагын нэгтгэл хүснэгтийг бөглөнө үү.

Сайн туршлагын нэр	Хэмжих үзүүлэлтүүд	Тайлбар, баталгаажуулалт
Хэрэгжүүлэгч	<ul style="list-style-type: none"> • АУБ, багш, сургуулийн удирдлага, • Эцэг эх • Төрийн байгууллага • Төрийн бус байгууллага /ТББ/, • Олон улсын байгууллага /ОУБ/ 	
Сайн туршлагын агуулга	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн сурлагын чанарыг дээшлүүлэх • Амьдрах нөхцлийг сайжруулах • Сургуульдаа ирэх, явах замыг аюулгүй болгох • Сургуулийн орчныг сайжруулах • Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийн эсрэг бодлого боловсруулах • Сурагчдын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөгөө, мэдээллээр хангах • Нөхцөл байдлыг даван туулахад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх • Сургалтыг зохион байгуулах • Хүүхдийн эрүүл мэндэд ээлтэй тоног төхөөрөмжөөр хангах • Бусад 	

Сайн туршлагын үр дүн, үр нөлөө	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн сурлагын чанар дээшилсэн. • Дотуур байранд амьдрах нөхцөл сайжирсан. • Сургуульдаа айдасгүй, аюулгүй явдаг болсон. • Хэн нэгний зүгээс дээрэлхэх, дарамтлах тохиолдолд хэнд хандахаа мэддэг болсон. • Сурагчдын ойлголт, мэдлэг нэмэгдсэн. • Ганцаарчилсан зөвлөгөө өгдөг болсон. • Эцэг эхийн оролцоо нэмэгдсэн. • Хүүхдийн нийгэмшлийг дэмжих зуны сургалт зохион байгуулсан. • Хүүхдийн сурч боловсроход таатай тоног төхөөрөмжөөр хангасан. • Бусад 	
Хэрэгжих боломж	<ul style="list-style-type: none"> • Дүрэм журам, хөтөлбөрийг баталсан. • Багшийн идэвх санаачлага нэмэгдсэн. • Хүүхэд хамгааллын хамтарсан багт сургуулийн нийгмийн ажилтан ажилладаг. • Эцэг эх идэвх, санаачлагатай оролцдог болсон. • Хүүхдийн зуслантай гэрээ байгуулсан. • Бусад 	
Тогтвортой байдал	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн төлөвлөгөөнд тусгана. • Сургуулийн удирдлага, багш, эцэг эхэд туршлагыг хэрэгжүүлэх сэдэл, сонирхол байна. • Бусад 	
Сургамж	<ul style="list-style-type: none"> • Туршлагыг илүү үр дүнтэй байлгах саналууд 	



UIH.MN
СУДАЛГААНЫСАН